



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРТ БАРИМТЛАХ ЖЕНДЭРИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

(Эхний үе шат 2018-2021)

Монголын эмэгтэйчүүдийн сангийн (МОНЭС) ИМПАКТ төсөл хэрэгжиж буй орон нутгийн жишээн дээр:

- Архангай аймгийн Эрдэнэбулган, Жаргалант, Цэцэрлэг сум,
- Хэнтий аймгийн Хэрлэн, Мөрөн, Биндэр сум



© 2022

Монголын эмэгтэйчүүдийн сан
(МОНЭС) ИМПАКТ төсөл

Судалгааны дүн шинжилгээг бичсэн:

Зөвлөх: С.Түмэндэлгэр, доктор, дэд проф
Ц.Одгэрэл, докторант

Судалгааны дүн шинжилгээг хянан тохиолдуулсан:

Монголын эмэгтэйчүүдийн сан (МОНЭС)-ийн Хөтөлбөр хариуцсан захирал:
Ц. Даваадулам

Энэхүү үнэлгээний тайланг Европын Холбооны санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “ИМПАКТ – Хөдөө орон нутгийн эдийн засгийн хөгжилд жендэрийн эрх тэгш оролцоог хангах” төслийн хүрээнд хийв.

Агуулга

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРТ БАРИМТЛАХ
ЖЕНДЭРИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Зураг, матрицын жагсаалт	3
Товчилсон үгсийн жагсаалт	4
Удиртгал.....	5
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт баримтлах жендэрийн бодлогын талаарх танилцуулга	8
Бүлэг 1. Салбарын бодлого төлөвлөлтийн хэрэгжилтийг дэмжих жендэрийн тэгш байдлын үзэл баримтлал, арга зүйг нэвтрүүлэх	9
Хоёр. Орон нутгийн бодлого, хөтөлбөр дэх уялдаа, бүтэц, мэдээлэл	19
Бүлэг 3. Мал аж ахуйн салбарын хүний нөөцийн хөгжил, эмэгтэйчүүдийн оролцоо	26
Бүлэг 4. Газар тариалангийн салбарын хүний нөөцийн хөгжил, эмэгтэйчүүдийн оролцоо	37
Бүлэг 5. Ялгаварлан гадуурхалт, АББД-аас урьдчилан сэргийлэх, хамгаалах	46
Дүгнэлт, зөвлөмж	47
Ашигласан материал.....	50

Зураг, матрицын жагсаалт

Матриц 1. 1 Салбарын жендэрийн бодлогыг өзб сайтдаа байршуулсан яамны харьяа байгууллагууд	10
Матриц 1. 2 Салбарын жендэрийн бодлогыг өзб сайтдаа байршуулсан аймгийн ЗДТГ, ХХААГ	11
Матриц 1. 3 ХХААХҮЯ-наас гадаад улс орнууд, олон улсын байгууллагуудын санхүү, техникийн туслалцаатай хэрэгжүүлсэн, хэрэгжүүлж буй төслүүдэд нийгэм, жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлого баримталдаг байдал, 2020-2021 оны ХШҮ-ний тайлан	14
Матриц 1. 4 Үндэсний хэмжээний бодлого, хөтөлбөрүүдийн тайлан, хяналт шинжилгээний тайланд хүйсээр ангилсан мэдээлэл тусгагдсан байдал	16
Матриц 2. 1 ОНЖДХ-т малчин эрэгтэй, эмэгтэйчүүдийн асуудал туссан эсэх (Архангай, Хэнтий аймаг)	20
Матриц 2. 2 ОНЖДХ-ийн хэрэгжилт, аймгаар	21
Матриц 2. 3 Салбарын жендэрийн бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх бүтэц бүрэлдсэн эсэх, бодлогын талаарх мэдлэг	23
Матриц 2. 4 Зорилтот сумдын бодлогын баримт бичиг дэх уялдаа	25
Матриц 2. 5 Бодлогын баримт бичиг дэх арга хэмжээний хэрэгжилтийн байдал, 2021 болон 2022 оны байдлаар	26
Матриц 3. 1 ХХААХҮЯ “Монгол мал үндэсний хөтөлбөр” (2010-2021)-ийн хэрэгжилт, 2020 27	
Матриц 3. 2 МАА-н мэргэжилтэнг бэлтгэх, ХАБЭА-н талаар хэрэгжүүлж буй үйл ажиллагаа (жендэрийн мэдрэмжтэй байдал)	28
Матриц 3. 3 Залуу малчин, эмэгтэй малчдыг чадавхжуулах үйл ажиллагаа	30
Матриц 3. 4 Удирдлага дахь эрэгтэй, эмэгтэйчүүдийн төлөөлөл, сумдаар	31
Матриц 3. 5 Малчдыг чадавхжуулах арга хэмжээ, сумдаар	33
Матриц 3. 6 Малчдын хүүхдийн сургууль, цэцэрлэгт хамрагдалт, сумдаар	34
Матриц 4. 1 Газар тариалан эрхлэгч эмэгтэйчүүдийг чадавхжуулах чиглэлээр	39
Матриц 4. 2 Газар тариалангийн салбарт ХАБЭА, зохистой хөдөлмөрийн дадал олгох чиглэлд чадавхжуулах үйл ажиллагаа	41
Матриц 4. 3 Газар тариалангийн салбарт ажиллагч эмэгтэйчүүдийг ХАБЭА, зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлд чадавхжуулах үйл ажиллагаа	42
Матриц 4. 4. Газар тариалангийн салбарт ажиллагч эмэгтэйчүүдийн ажиллах нөхцлийг сайжруулах; сургалт, санхүү-зээлийн үйлчилгээг жендэрийн мэдрэмжтэй хөгжүүлэх хүрээнд ОНЖДХ-т төлөвлөгдсөн үйл ажиллагаа түүний хэрэгжилт	44

Товчилсон үгсийн жагсаалт

АББД	Ажлын байрны бэлгийн дарамт
АЗД	Аймгийн Засаг дарга
АЗДТГ	Аймгийн Засаг даргын Тамгын газар
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
ЖҮХ	Жендэрийн үндэсний хороо
ЖЭРЭС	Сэргээгдэх эрчим хүч, байгаль орчин, эв нэгдлийн бүлгэм
ИМПАКТ	“Хөдөө, орон нутгийн эдийн засгийн хөгжилд жендэрийн эрх тэгш оролцоог хангах нь” төсөл
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МАА	Мал аж ахуй
МОНЭС	Монголын эмэгтэйчүүдийн сан
МСҮТ	Мэргэжил, сургалт, үйлдвэрлэлийн төв
НҮБХААБ	Нэгдсэн үндэстний байгууллагын Хөдөө аж ахуйн байгууллага
ОНЖДХ	Орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөр
ОУБ	Олон улсын байгууллага
СЗД	Сумын Засаг дарга
СТРИЙМ	“Хөдөө аж ахуйн менежмент, экосистемийн тогтвортой байдлыг хангах” төсөл
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
ХАА	Хөдөө аж ахуй
ХААИС	Хөдөө аж ахуйн их сургууль
ХАБЭА	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
ХМХ	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХХМЭБА	Хил хязгааргүй малын эмч нар ба агрономичид
ХШҮ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ

Удиртгал

Үндэслэл

Монголын эмэгтэйчүүдийн сан Европын Холбооны дэмжлэгтэйгээр Хил хязгааргүй малын эмч нар ба агрономичид (ХХМЭБА), Сэргээгдэх эрчим хүч, байгаль орчин, эв нэгдлийн бүлгэм (ЖЭРЭС) олон улсын байгууллагуудтай хамтран “ИМПАКТ – Хөдөө орон нутгийн эдийн засгийн хөгжилд жендэрийн эрх тэгш оролцоог хангах” төслийг 2020 оны 1 дүгээр сараас эхлэн хэрэгжүүлж байна. ИМПАКТ төсөл нь алслагдсан орон нутгийн иргэдийн эрх тэгш оролцоог дэмжсэн эдийн засгийг тогтвортой хөгжүүлэх загвар боловсруулах зорилготой. Төслийн хүрээнд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарт хөдөлмөр эрхэлж буй эмэгтэйчүүдийг чадавхжуулж, шийдвэр гаргах түвшин дэх оролцоог нь нэмэгдүүлэх; эрчим хүчний хэмнэлтийн шийдлүүд, үйлдвэрлэлийн дэвшилтэт дадал, туршлагыг нэвтрүүлэх, хүрээлэн буй орчинд ээлтэйгээр байгалийн нөөцийг ашиглах замаар нэмүү өртөг шингэсэн орон нутгийн тогтвортой ноолуур, органик ногоо тариалангийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг дэмжин ажиллаж байна.

Энэхүү төслийн зорилго, хэрэгжүүлж буй үйл ажиллагаа нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт баримтлах жендэрийн бодлого, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний эхний үе шаттай (2018-2021) давхцаж байгаа бөгөөд тус бодлогын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх чиглэл, арга хэмжээг тодруулах үүднээс энэхүү үнэлгээний ажлыг гүйцэтгэв.

Үнэлгээний зорилго, зорилтууд

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт баримтлах жендэрийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө (эхний үе шат, 2018-2021)-ний хүрээнд мал аж ахуй, газар тариалангийн салбарт ажиллаж буй эмэгтэйчүүдийн ажиллах орчныг сайжруулах, тэднийг чадавхжуулах, шийдвэр гаргах түвшин дэх оролцоог нь нэмэгдүүлэх чиглэлээр төлөвлөсөн зорилт, үйл ажиллагааны хэрэгжилт үр дүнг сонгогдсон сумдын жишээн дээр судалж салбарын жендэрийн бодлогын хэрэгжилтийг сайжруулах санал, зөвлөмж боловсруулах зорилготой.

Үнэлгээний хүрээнд дараах асуултуудад анхаарал хандуулав. Үүнд:

1. Салбарын бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөө нь орон нутгийн малчин, ногоочин эмэгтэйчүүдийн бодит амьдралын хэрэгцээ, шаардлагад нийцсэн үү?
2. Салбарын бодлогын хэрэгжилтэд оролцогч талуудын оролцоо бүрэн хангагдсан уу, талууд хэрхэн оролцсон бэ?
3. Бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэх хугацааг оновчтой төлөвлөсөн үү?
4. Бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх санхүүжилт бүрдүүлсэн үү? Санхүүжилт хангалттай байсан уу?
5. Бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө бий юу? Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, зөвлөмж төлөвлөгөөний дагуу гарсан уу?

6. Орон нутгийн эмэгтэйчүүдийн хэрэгцээ шаардлага, бэрхшээлийг тодорхойлж, эмэгтэйчүүдийг чадваржуулж, амьдралын чанарыг сайжруулахад нөлөөлсөн үү?
7. Орон нутгийн малчин, ногоочин эмэгтэйчүүд үндэсний болон орон нутгийн удирдлагатай зөвлөлдөх, санал бодлоо хүргэх, шийдвэр гаргахад оролцох боломж бүрдүүлсэн үү?

Үнэлгээний арга зүй, мэдээлэл цуглуулах аргууд

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт жендэрийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг үнэлэхэд Монгол Улсын Засгийн газар, Жендэрийн үндэсний хороо, Азийн хөгжлийн банк хамтран хэрэгжүүлсэн “Иргэний нийгмийн оролцоотойгоор жендэрийн тэгш байдлыг хангах нь” техник туслалцааны төслийн хүрээнд боловсруулсан “Салбарын жендэрийн бодлогод оролцооны хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал” болон Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримтлав.

Дээрх аргачлалын хүрээнд баримт бичгийн шинжилгээ, ганцаарчилсан ярилцлага, фокус бүлгийн ярилцлагын аргуудыг ашиглав.

Үнэлгээний хамрах хүрээ

МОНЭС-гаас хэрэгжүүлж буй ИМПАКТ төсөл нь орон нутгийн малчин, хүнсний ногоо тариалагч эмэгтэйчүүдийг чадавхжуулах, амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэж байгаа тул ХХААХҮ-ийн салбарын жендэрийн бодлогын хөдөө аж ахуй, ялангуяа мал аж ахуй, газар тариалангийн салбарт чиглэсэн зорилт, үйл ажиллагааны хэрэгжилтийг үнэлэхэд чиглэлээ. Түүнчлэн ХАА-н албан бус салбарт ажиллагч эмэгтэйчүүдийг зорилтот бүлэг болгон авч судалсан бөгөөд хувийн хэвшлийн албан салбарыг судалгаанд хамруулаагүй болно.

Үнэлгээнд төсөлд хамрагдаж буй Архангай аймгийн Эрдэнэбулган, Жаргалант, Цэцэрлэг сум, Хэнтий аймгийн Хэрлэн, Мөрөн, Биндэр сумын Засаг даргын Тамгын газар (ЗДТГ), аймаг, сумын Хүнс, хөдөө аж ахуйн газар (ХХААГ), тасгийн удирдлага, мэргэжилтнүүд болон малчин, хүнсний ногоо тариалагч эмэгтэйчүүдийг судалгаанд хамруулав. Ганцаарчилсан ярилцлагад төв, орон нутгийн төрийн захиргаа, нутгийн удирдлагын байгууллагын 8 хүн, фокус бүлгийн ярилцлагад сумдын малчин, хүнсний ногоо, хүлэмжийн аж ахуй эрхлэгч нийт 36 хүн оролцлоо.

Судалгааны хязгаарлагдмал байдал

Үнэлгээний мэдээлэл цуглуулах шатанд зарим хүчин зүйлээс шалтгаалан баримт бичгийн шинжилгээ хийхэд дараах бэрхшээлүүд тохиолдов.

- Төв, орон нутгийн захиргааны байгууллагын баримт бичгүүд жишээлбэл яам, аймаг, сумын ЗДТГ-ын Хөдөлмөрийн дотоод журам, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, хэрэгжилтийн тайлан зэрэг холбогдох баримт бичиг зөвхөн нэг ажилтанд хадгалагдаж, бүх ажилтанд хүртээмжгүй байдгаас үнэлгээнд хамаарах баримт бичиг бүрдүүлэхэд төлөвлөснөөс их хугацаа зарцууллаа.
- Орон нутгийн захиргааны байгууллагын ажилтнуудын дунд жендэрийн асуудлыг өөрийн ажил үүргийн нэг хэсэг гэж үзэх хандлага байхгүйгээс шаардлагатай баримт бичгийг гаргаж өгөхөд хойргошоох, ач холбогдол өгч дэмжлэг үзүүлэхгүй байсан нь мэдээлэл цуглуулах ажил сунжрахад хүргэлээ.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт баримтлах жендэрийн бодлогын талаарх танилцуулга

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт жендэрийн талаар баримтлах бодлого, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг ХХААХҮ-ийн сайдын 2018 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн А-94 тоот тушаалаар баталжээ. Бодлого нь Засгийн газрын Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр (2017-2021), Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого (2014-2025), Төрөөс малчдын талаар баримтлах бодлого (2009-2020), Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого (2015-2030) болон салбарын бусад бодлого төлөвлөлт, үйл ажиллагаатай уялдан хэрэгжинэ.¹

Бодлогын зорилгыг “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын тогтвортой хөгжлийг жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаа, хяналт-шинжилгээ, үнэлгээгээр дэмжинэ” гэж тодорхойлсон бөгөөд дараах гурван үндсэн зорилт дэвшүүлжээ. Үүнд:

- Салбарын бодлого төлөвлөлтийн хэрэгжилтийг дэмжих жендэрийн тэгш байдлын үзэл баримтлал, арга зүйг нэвтрүүлэх;
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын хүний нөөцийн хөгжлийг дэмжин жендэрийн тэгш оролцоо, тэгш хариуцлагыг бүх түвшинд нэмэгдүүлэх;
- Үндэсний ба олон улсын түвшин дэх жендэрийн түншлэл, хамтын ажиллагаагаар хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын хөгжлийг дэмжих.

Бодлогыг хоёр үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба эхний үе шатыг 2018- 2021 онд Засгийн газраас 2017-2021 онд хэрэгжүүлэх “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр”-ийн үйл ажиллагааны хэрэгжилт, хоёрдахь үе шатыг 2022-2025 онд “Монгол Улсын Алсын Хараа 2050”-ын хэрэгжилттэй тус тус уялдуулан хэрэгжүүлэхээр тогтсон.

Бодлого, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах санхүүгийн эх үүсвэрийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэл, улсын төсөвт тусгах, олон улсын төсөл, хөтөлбөрт хамруулах замаар шийдвэрлэхээр тодорхойлсон байна. Бодлогын хэрэгжилтийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу одоогийн ХХААХҮЯ дахь Жендэрийн Үндэсний Хорооны салбар зөвлөл удирдан зохион байгуулж байна.

¹ ХХААХҮЯ. 2018. ХХААХҮ-ийн салбарт жендэрийн талаар баримтлах бодлого. Хуудас 3

Бүлэг 1. Салбарын бодлого төлөвлөлтийн хэрэгжилтийг дэмжих жендэрийн тэгш байдлын үзэл баримтлал, арга зүйг нэвтрүүлэх

Монгол Улсын Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль (ЖЭТБХТХ), Засгийн газрын 2017 оны 129 дүгээр тогтоолоор батлагдсан “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр 2017-2021”, ХХААХҮ-ийн сайдын 2018 оны 5 дугаар сарын 1-ны тушаалаар “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт жендэрийн талаар баримтлах бодлого”-д тус тус заасны дагуу ХХААХҮЯ нь салбарын хэмжээнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлж байна. ХХААХҮЯ нь ЖЭТБХТХ-ийн чиг үүргийн дагуу Жендэрийн салбар зөвлөл (ЖСЗ) байгуулан ажилладаг ба Жендэрийн үндэсний хороонд тайлагнадаг. Бодлогын хэрэгжилтийг хангах хүрээнд УИХ-ын 2009 оны 39 дүгээр тогтоолоор баталсан “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого 2009-2020”, 2015 оны 104 дүгээр тогтоолоор баталсан “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн салбарт баримтлах бодлого (2014-2025)”-ыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг хүлээж буй.

ХХААХҮ-ийн салбарын жендэрийн бодлогод уг бодлогыг хэрэгжүүлэх тогтолцоог хөгжүүлэх, салбарын бодлого төлөвлөлт, үнэлгээнд жендэрийн дүн шинжилгээ, жендэрийн үнэлгээ, жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн арга зүйг нэвтрүүлэх, жендэрийн статистик мэдээлэл, жендэрийн шалгуур үзүүлэлт ашиглах, жендэрт ээлтэй байгууллагын соёлыг бүтээх төрийн албаны манлайллыг хөгжүүлэх зорилтуудыг дэвшүүлсэн.

Салбарын жендэрийн бодлогыг хэрэгжүүлэх тогтолцоо

Энэ хүрээнд 2018-2021 онд ХХААХҮ-ийн салбарын жендэрийн бодлогын баримт бичгийг салбарт ажиллагсад болон олон нийтэд таниулах, түгээх, салбарт ажиллагсдын жендэрийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, Жендэрийн салбар зөвлөл (ЖСЗ) байгуулах зэргээр тодорхой алхмууд хийгдэж байна. Гэвч салбарын жендэрийн бодлогыг хэрэгжүүлэх үндэсний тогтолцоог хөгжүүлэхэд ХХААХҮЯ болон түүний харьяа байгууллагуудын удирдлага, манлайлал, оролцоо хангалтгүй байна.

Салбарын бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд яамны ЖСЗ-ийг төр, төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагын төлөөлөлтэйгээр өргөтгөх, гишүүдийн үүргийг ялгамжтай тогтоох, ЖСЗ-ийн дүрэм шинэчлэх зэрэг ажлууд тусгагдсан ч одоогийн байдлаар ЖСЗ-ийн бүрэлдэхүүн шинэчлэгдээгүй байна. Харьяа байгууллагуудад жендэрийн дэд салбар зөвлөл байгуулах, бүрэлдэхүүнийг шинэчлэх, жендэрийн асуудал хариуцсан ажилтан томилох чиглэлээр санаачилга гарч байна. Тухайлбал байгууллага бүрд жендэрийн дэд салбар зөвлөл байгуулж ажиллах, гишүүдийн хүйсийн тэнцвэрийг хангах, жендэрийн талаарх хууль тогтоомж, хөтөлбөр, бодлогыг хэрэгжүүлэх талаар яамны харьяа байгууллага болон аймгуудын ХХААГ-т албан тоот хүргүүлж, үүрэг болгожээ. Үүний үр дүнд Жижиг дунд үйлдвэрийн газар Жендэрийн дэд салбар зөвлөл байгуулснаар ЖДҮ-ийг дэмжих сангаас олгох зээлийн баримт бичгүүдэд иргэний хүйс болон хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдээллийг тусган, үйл ажиллагаандаа ашиглаж эхэлж байна.

ХХААХҮЯ-ны ТНБД-ын 2019 оны 10-р сарын 23-ны 01/4063, 2020 оны 01/3506 тоот албан бичгийг харьяа байгууллагууд, аймгуудын ХХААГ-т илгээж, жендэрийн салбарын бодлогыг вэб хуудсанд байршуулах үүрэг болгосныг яамны харьяа 6 байгууллага, 4 аймгийн ХХААГ биелүүлжээ (Матриц 1.1, 1.2).

Салбарын жендэрийн бодлогыг хэвлүүлэн 2019-2020 онд Улаанбаатар хот, Дорнод, Төв, Сэлэнгэ аймагт мал аж ахуй, газар тариалан, жендэрийн чиглэлээр зохион байгуулагдсан бүсийн уулзалт, сургалт, хэлэлцүүлэг, ур чадварын уралдаант тэмцээний үеэр түгээж сурталчилжээ. Гэвч яамны харьяа 3 байгууллага, 17 аймгийн ХХААГ вэб сайтдаа байршуулаагүй байгаа бөгөөд судалгаанд хамрагдсан аймаг, сумдын ХАА газрын мэргэжилтнүүд салбарын жендэрийн бодлого гарсан талаар мэдээлэлгүй байгаа нь мэдээллийн хүртээмж хангалтгүй байгааг харуулж байна.

Матриц 1. 1 Салбарын жендэрийн бодлогыг вэб сайтдаа байршуулсан яамны харьяа байгууллагууд

д/д	Яам, харьяа газрын нэр	Вэб сайтдаа байршуулсан эсэх	
1.	ХХААХҮЯ	Тийм	
2.	Мал эмнэлгийн ерөнхий газар		үгүй
3.	Жижиг, дунд үйлдвэрийн газар	Тийм	
4.	Малын удмын сангийн үндэсний төв		үгүй
5.	Аймаг дундын отрын бэлчээрийн ашиглалтын захиргаа		Вэб сайт ажиллахгүй
6.	Хөдөө аж ахуйг дэмжих сан	Тийм	
7.	ХХААХҮ-ийн судалгаа, хөгжлийн төв		Вэб сайт ажиллахгүй
8.	ХАА-н Халхгол ҮБББЗ	Тийм	
9.	Хөдөө аж ахуйн бирж ТӨХХК		Вэб сайт ажиллахгүй

Матриц 1. 2 Салбарын жендэрийн бодлогыг вэб сайтдаа байршуулсан аймгийн ЗДТГ, ХХААГ

д/д	21 аймгийн ХХААГ болон ИМПАКТ төсөлд хамрагдсан сумд	Вэб сайтдаа байршуулсан эсэх	
1.	Архангай, ХХААГ	Тийм	
	Эрдэнэбулган сум		Үгүй
	Жаргалант сум		Үгүй
	Цэцэрлэг сум		Вэб сайт шинэчлэгдэж байгаа
2.	Баян-Өлгий, ХХААГ		Вэб сайт ажиллахгүй
3.	Баянхонгор, ХХААГ		Вэб сайт ажиллахгүй
4.	Булган, ХХААГ	Тийм	
5.	Говь-Алтай, ХХААГ	Тийм	
6.	Говьсүмбэр, ХХААГ		Үгүй
7.	Дархан-Уул, ХХААГ		Үгүй
8.	Дорноговь, ХХААГ		Үгүй
9.	Дорнод, ХХААГ		Үгүй
10.	Дундговь, ХХААГ	Тийм	
11.	Завхан, ХХААГ		Хайх боломжгүй
12.	Орхон, ХХААГ		Үгүй
13.	Өвөрхангай, ХХААГ		Үгүй
14.	Өмнөговь, ХХААГ		Үгүй
15.	Сүхбаатар, ХХААГ		Үгүй
16.	Сэлэнгэ, ХХААГ		Үгүй
17.	Төв, ХХААГ		Үгүй
18.	Увс, ХХААГ		Хайх боломжгүй
19.	Ховд, ХХААГ		Вэб сайт ажиллахгүй
20.	Хөвсгөл, ХХААГ		Үгүй
21.	Хэнтий, ХХААГ		Үгүй
	Биндэр сум		Үгүй
	Мөрөн сум		Үгүй
	Хэрлэн сум		Үгүй

Салбарын ажилтнуудын жендэрийн талаарх ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх, удирдлагын манлайллыг хөгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд яамны 6, харьяа байгууллагын 11 газар, албадын дарга нар төрийн удирдах албан тушаалтанд зориулсан “Жендэрийн цахим сургалт”-ад бүрэн хамрагдаж, сертификат авсан ба яамны жендэр хариуцсан мэргэжилтэн Жендэрийн үндэсний хорооноос зохион байгуулсан сургагч багшийн дунд шатны сургалтад мөн хамрагджээ. Харин орон нутгийн ХХААГ-уудад бүсчилсэн арга хэмжээ зохион байгуулж мэдээлэл өгөх, мэдлэг олгох, чадавхжуулах ажлууд төлөвлөсөн боловч биелэгдээгүй нь нэг талаас шаардагдах төсөв хуваариалаагүй, нөгөө талаас ковидын нөхцөл байдлаас шалтгаалан Төрийн хяналт, шалгалтын тухай хуулийн дагуу биечилсэн уулзалт, сургалтуудыг хориглосон зэрэг шалтгаан нөлөөлжээ. Харин гадаад орнууд, олон улсын байгууллагуудын санхүү, техникийн туслалцаатай орон нутагт хэрэгжүүлж буй

төслүүдийн хүрээнд малчид, ногоочид жендэрийн талаарх сургалтад хамрагдаж, мэдлэг ойлголтоо нэмэгдүүлж байна. Тухайлбал МОНЭС-ийн Архангай, Хэнтий аймагт хэрэгжүүлж буй ИМПАКТ төсөл, Европын холбооны дэмжлэгтэй хэрэгжүүлж буй СТРИЙМ төслүүд аймаг, сумын ЗДТГ-ын мэргэжилтнүүд, орон нутгийн малчид, хүнсний ногоо, хүлэмжийн аж ахуй эрхэлж буй иргэдэд зориулсан сургалт зохион байгуулжээ.

Шигтгээ 1. 1

Сумын ЗДТГ-аас жендэрийн талаар сургалт зохион байгуулаагүй. Төсөв байдаггүй. ИМПАКТ төслийн хүрээнд тамгын газрын ажилтнууд жендэрийн сургалтад хамрагдсан.

Ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэлээс, сумын ХХААТ-ын мэргэжилтэн, Архангай аймаг

Салбарын бодлогыг хэрэгжүүлэхэд салбарын мэргэжилтнүүдийн оролцоог хангахын тулд харьяа агентлаг, аймгуудын ХХААГ, сумдын ХХАА-ын тасгийн мэргэжилтнүүдийг сэлгээгээр жендэрийн асуудал хариуцуулуулан ажиллуулах удирдамж боловсруулж сонгосон агентлаг, орон нутгийн байгууллагад туршихаар төлөвлөсөн байв. Гэвч энэ үйл ажиллагааг хэрэгжүүлж эхлээгүй, ажлын удирдамж боловсруулаагүй, туршилт эхлээгүй байна. Одоогоор ХХААХҮЯ-ны харьяа байгууллага, орон нутгийн ХХААГ-ын хүний нөөцийн мэргэжилтнүүд, аймаг, сумын ЗДТГ-ын нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтнүүд жендэрийн асуудлыг давхар хариуцан ажиллаж байгаа ба сумдын ХХАА-н тасагт жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн байхгүй байна. Сумдын ХХАА-н тасгийн мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлагаас үзвэл тэдний жендэрийн болон салбарын жендэрийн бодлогын тухай ойлголт, мэдээлэл дутмаг ба үүний бэлтгэл хангах арга хэмжээг үе шаттай зохион байгуулах шаардлагатай нь судалгааны явцад харагдлаа.

Шигтгээ 1. 2

Бид жендэрийн асуудлаар мэдээлэл багатай байдаг юм байна. Судалгаа авсан та бүхнээс маш их мэдээлэл авлаа. Салбарынхаа хувьд хүнтэй ажиллах талаас бодож байгаагүй, бас нийгмийн бодлогын мэргэжилтэн гээд бусад мэргэжилтнүүдтэй өөр хоорондоо хамтарч ажилладаггүй юм байна.

Ганцаарчилсан ярилцлагаас, сумын ХХАА-н тасгийн мэргэжилтэн, Хэнтий аймаг

Түүнчлэн судалгаанд хамрагдсан зарим сумын ХХАА-н тасгийн мэргэжилтэн хоёр, гурван хүний орон тоонд ажиллаж байгаа нь орон нутагт ажиллагсдын ажлын ачааллыг оновчтой хуваарилахад анхаарах шаардлагатайг харуулж байна. Жишээлбэл Хэнтий аймгийн Биндэр сумын ХАА тасгийн мэргэжилтэн хүнс, МАА, ЖДҮ асуудлыг хариуцдаг, Мөрөн сумын ХАА тасгийн мэргэжилтэн МАА, хүнс, ЖДҮ, хоршоо, газар тариаланг бүгдийг хариуцан ажиллаж байна. Түүнчлэн, хэмнэлтийн хуулиар тасгийн эрхлэгчгүй болгосон нь удирдлага, менежментийн хувьд эзэнгүйдэх үр дагаварт хүргэж болзошгүй байна.

Шигтгээ 1.3

Сумдын ХАА-н тасаг нь 3 орон тоотой байхаар батлагдсан боловч мэргэжлийн ажиллах хүчний дутагдалтай, орон нутагт ирж ажиллах залуучууд хомс, цалин бага, төрийн албанд ажиллахыг хүсдэг ч шалгалтад тэнцдэггүй зэргээс үүдэлтэй орон тооны хувьд дутагдалтай, ажлын ачаалал өндөр байдаг тул 1 мэргэжилтэн 2-3 өөр чиг үүргийн ажил үүрэг хариуцан ажилладаг. Тиймээс жендэр тусгайлан хариуцсан албан хаагчгүй байдаг.

Ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэлээс, аймгийн ХХААГ-ын албаны дарга

Салбарын бодлого төлөвлөлтөд жендэрийн дүн шинжилгээ, жендэрийн үнэлгээ, жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн арга зүй

Тодорхой хууль, тогтоомж, бодлогын баримт бичиг, хөтөлбөрт үнэлгээ хийх, тухайлбал Бэлчээрийн тухай хуулийн төсөлд хийсэн жендэрийн үр нөлөөний үнэлгээ хийх, Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн төсөвт жендэрийн дүн шинжилгээ хийх зэрэг ажлууд төлөвлөгдсөн ч бодлогын хэрэгжүүлэх эхний үе шатанд хэрэгжээгүй байна.

Хууль тогтоомж, бодлого хөтөлбөрийн төсөлд жендэрийн үнэлгээ хийх аргачлалыг ХХААХҮ-ийн салбарт нэвтрүүлж хэрэглэхээр төлөвлөсөн ч энэ нь үндэсний болон байгууллагын түвшинд хэрэгжиж эхлээгүй байна. Тухайлбал, ХХААХҮ-ийн сайдын 2020 оны 2-р сарын 8-ны өдрийн А-28 тоот тушаалаар баталсан “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын стратеги төлөвлөгөө (2021-2024) орчны шинжилгээнд жендэрийн үнэлгээ, дүн шинжилгээ хийгдээгүй, стратегийн зорилго, зорилт, шалгуур үзүүлэлтэд жендэрийн үзүүлэлт тусгагдаагүй байна. Мөн ХХААХҮЯ-ны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд жендэрийн үзүүлэлтүүд тусгагдаагүй. Энэ нь жендэрийн эрх тэгш байдлыг хангах асуудал үндэсний болон салбарын төлөвлөлт, бодлогын гадна үлдэж байгааг харуулж байна.

Энэ хугацаанд оролцогч талуудыг чадавч бэхжүүлэх сургалтуудад холбогдох мэргэжилтнүүд, төрийн бус байгууллагуудын төлөөллийг хамруулсан байна. Жишээлбэл, ХХААХҮЯ, НҮБ-ын ХХААБ-тай хамтран “Мал аж ахуйн салбар дахь жендэрийн дүн шинжилгээ” сургалтыг 2019 онд зохион байгуулсан ба сургалтад 21 аймгийн ХХААГ-ын хүний нөөцийн болон мал аж ахуйн мэргэжилтэн, харьяа байгууллагын албан хаагчид оролцжээ. Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба, Азийн Хөгжлийн Банк хамтран хэрэгжүүлсэн “Иргэний нийгмийн оролцоотойгоор жендэрийн тэгш байдлыг хангах нь” төслийн хүрээнд 2021 онд зохион байгуулсан “Оролцооны хяналт-шинжилгээ, үнэлгээ” сургалтад үр тариа, төмс хүнсний ногоо, жимс жимсгэнэ, зөгий, хүлэмж, зоорь зэрэг газар тариалан, хүнс, хөнгөн үйлдвэрлэл, жижиг дунд үйлдвэр, бүтээгдэхүүн, мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг ТББ-уудын төлөөлөл болон яамны жендэрийн болон ХШҮ хариуцсан мэргэжилтнүүд хамрагджээ.

Олон улсын байгууллагуудын хөнгөлөлттэй зээл, техник тусалцааны хүрээнд хэрэгжүүлж буй төслүүдийн хэрэгжилтэд нийгэм-жендэрийн үнэлгээ хийж, хүйсийн тэгш байдлын бодлогод нийцүүлэх бодлого баримталж байна. Тухайлбал АХБ-ны

буцалтгүй тусламжаар хэрэгжүүлж буй “Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах” төслийн явцын ХШҮ-ний тайлангууд жендэрийн асуудлуудыг тусгадаг ба жендер, нийгмийн мэргэжилтэн ажилладаг, мөн Швейцарын хөгжлийн агентлагийн буцалтгүй тусламжаар хэрэгжүүлж буй “Хүнсний ногооны тогтвортой үйлдвэрлэл, маркетинг” төслийн төлөвлөлт, хяналт, хэрэгжүүлэлт, шийдвэр гаргах, тэргүүн туршлага нэвтрүүлэх зэрэг бүхий л үйл ажиллагаандаа хүйсийн тэнцвэртэй байдлыг хангахад анхаарч, эмэгтэй оролцогчид, фермерүүдийг тэнцвэртэй байдлаар оролцуулахад анхааран ажиллаж байна.

Матриц 1.3-д олон улсын байгууллагуудаас мал аж ахуй, газар тариалангийн салбарт хэрэгжүүлж буй төслүүдэд жендэрийн бодлого, тодорхой загваруудыг тусгасан байдлыг харуулав. Эдгээр загварыг салбарын болон орон нутгийн бодлого, хөтөлбөрүүдэд тусгах боломжтой юм.

Матриц 1. 3 ХХААХҮЯ-наас гадаад улс орнууд, олон улсын байгууллагуудын санхүү, техникийн туслалцаатай хэрэгжүүлсэн, хэрэгжүүлж буй төслүүдэд нийгэм, жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлого баримталдаг байдал, 2020-2021 оны ХШҮ-ний тайлан

д/д	Төслийн нэр	Санхүүжүүлэгч
1	2	3
1.	“Монгол ногоо” төсөл, 2020-2023 Төслийн зорилго: Хүртээмжтэй, хүйсийн тэгш байдлыг хангасан тогтвортой өсөлтийг хүнсний ногооны салбарт бий болгох замаар иргэдийн амьжиргааг сайжруулна	Швейцарийн хөгжлийн агентлаг
2.	“Ногоон алт-Малын эрүүл мэнд” төсөл, 2017-2021 Төслийн зорилго: Бэлчээрийн зохистой ашиглалт, борлуулалтын ашигтай тогтолцоо, эрхзүй, бодлогын таатай орчны нөлөөгөөр малчин өрхийн амьжиргаа дээшлэх	Швейцарийн хөгжлийн агентлаг
3.	“Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил, Нэмэлт санхүүжилт” төсөл, 2017-2021 Төслийн зорилго: “Хоршоог хөгжүүлэх”, “Монгол мал” хөтөлбөрүүдийн хэрэгжилттэй уялдуулан хөрөнгө оруулалт хийх, төслийн аймаг, сумын төвийн ядуу иргэд болон малчдын амьжиргааг сайжруулж, ядуурлыг бууруулах.	Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сан
4.	“Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах” төсөл, 2018-2022 Төслийн зорилго: Хүнсний ногооны үр үйлдвэрлэлийг бэхжүүлэх, 5 хүртэл га талбайтай иргэн, хуулийн этгээдийг дэмжиж тариалангийн ажлыг механикжуулах, дуслын усалгааны технологи нэвтрүүлэх, механикжсан зоорь, өвөл, зуны хүлэмжийн тоо хэмжээ, хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар импорт, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, дотоодын үйлдвэрлэлээр хүнсний ногооны хэрэгцээг хангах	Азийн хөгжлийн банк
1	2	3
5.	“Хувийн хэвшлийн оролцоотойгоор мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн болон хүнсний ногооны үйлдвэрлэлийн өртөгийн сүлжээг хөгжүүлэх” Төсөл, 2016-2020 Төслийн зорилт: Мал аж ахуй болон хүнсний ногооны салбарын нэмүү өртгийн сүлжээнд хувийн хэвшлийн салбарын ажлын байр бий болгох нөхцлийг сайжруулах, чадавхыг бэхжүүлэх	Европын холбоо

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХҮЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРТ БАРИМТЛАХ
ЖЕНДЭРИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

6.	<p>“Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил” төслийн нэмэлт санхүүжилт” төсөл, 2016-2020 Төслийн зорилго: Агробизнесийн чиглэлийн хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдэд хөрөнгө оруулах замаар хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийг дэмжин ажлын байрыг бий болгох.</p>	Азийн хөгжлийн банк
7.	<p>“Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх” төсөл, 5 жил Төслийн зорилго: Малын эрүүл мэнд, үр ашиг, бүтээмж болон төсөл хэрэгжих газрууд дахь нэмүү өртгийн сүлжээний эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх, онцгой нөхцөл байдал, гамшгийн үед шуурхай үр дүнтэй хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх.</p>	Дэлхийн банк
8.	<p>“Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй” төсөл, 2020-2026 Төслийн зорилго: Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, үр ашигтай усжуулалтын систем бий болж, менежментийн тогтолцоо бүрдүүлэх, байгаль орчны хувьд тогтвортой хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн тогтолцоог сайжруулах, мэргэжил арга зүй, институци ба удирдлагын чадавх болон уялдаа зохицуулалтыг сайжруулах.</p>	Азийн хөгжлийн банк Ядуурлыг бууруулах Япон

Жендэрийн мэдрэмжтэй төсвийн төлөвлөлтийг нэвтрүүлэхээр төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлээгүй боловч орон нутгийн төрийн албан хаагчид мэдлэг, ойлголт нэмэгдүүлэх зарим сургалтуудад хамрагдсан байна. Тухайлбал Дундговь аймгийн 12 албан хаагч “Жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт” сэдэвт анхан ба ахисан шатны түвшний сертификат олгох цахим сургалтад хамрагдаж мэдлэг, ойлголтоо дээшлүүлснээр орон нутагт жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн арга зүйг нэвтрүүлэх хүний нөөцийн чадавх бэхжүүлэх ажлын эхлэл тавигдаж байна.

Салбарын бодлого төлөвлөлт, ХШҮ-нд жендэрийн статистик мэдээлэл, жендэрийн шалгуур үзүүлэлт ашиглах

Төлөвлөсөн үйл ажиллагааны хэрэгжилт хангалтгүй байгаа ч салбарын хэмжээнд хүйсээр ангилсан мэдээлэл цуглуулах, түүнийг ашиглах арга зүйд сургах, чадавх бэхжүүлэхэд чиглэсэн зарим арга хэмжээ авч эхэлж байна. ХХААХҮ-ийн сайдын 21 аймгийн Засаг дарга болон ХХААГ-ын дарга нартай 2020 онд байгуулсан үр дүнгийн гэрээнд салбарын бүх тайлан мэдээ, хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан, ХШҮ-ний тайлангуудад хүнтэй холбоотой мэдээллийг хүйсээр ангилан харуулж байх талаар чиглэл өгчээ. Үүний үр дүнд Өмнөговь, Дундговь, Увс, Хөвсгөл, Сэлэнгэ, Сүхбаатар аймгуудаас ирүүлсэн тайланд дараах мэдээллийг хүйсээр ангилан гаргажээ. Үүнд:

- Малчдын тоо
- Тэргүүний тариаланч, Аварга малчин, саальчин, фермерийн тоо, өрх толгойлсон эмэгтэйн тоо,
- ХАА тасгийн ажиллагсдын тоо
- Газар тариалан эрхлэгчдийн тоо, эрхлэх аж ахуй төрлөөр
- Сургалт, зөвлөгөөн, хэлэлцүүлэгт хамрагдсан малчид, тариаланчид, иргэдийн тоо
- Байгууллагаар үйлчлүүлсэн иргэдийн тоо

Сэлэнгэ аймгийн аймгийн ЗДТГ, Үндэсний статистикийн хорооноос зохион байгуулсан “Жендэрийн статистик ба тогтвортой хөгжлийн үзүүлэлт, түүнийг ашиглах” сургалт, хэлэлцүүлэгт тус аймгийн 12 сумын ЖДҮ болон өрхийн аж ахуй эрхлэгч 65 эмэгтэйг хамруулжээ.

ХХААХҮ-ийн салбарт холбогдох үндэсний хэмжээнд гардаг статистик үзүүлэлтүүд нь үндэсний түвшинд жендэрийн статистик хангалтгүй байгааг харуулж байна. Тухайлбал ҮСХ-ноос улирал бүр нэгтгэн гаргадаг Ажиллах хүчний судалгааны 2021 оны 4-р улирлын тайланд ажиллагчдын тоог эдийн засгийн үйл ажиллагааны салбар, орон нутгаар ялган гаргадаг ч хүйсээр ангилдаггүй. Салбарын бодлого төлөвлөлтөд шаардлагатай хүйсээр ангилсан мэдээлэл дутмаг байдал нь салбар болон яамны түвшинд жендэрийн статистик хэрэглэх боломжгүйд хүргэж байна.

Яамны дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээнд хүйсээр ангилсан багц үзүүлэлт гаргах, бодлого төлөвлөлтөд ашиглалт хэрэгжихгүй байгаа нь үндэсний хэмжээнд хэрэгжиж буй хөтөлбөрүүд, тухайлбал “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”, “Монгол Малчин”, “Эрчимжсэн мал аж ахуй”, “Хүнсний ногоо”, “Жимс, жимсгэнэ” зэрэг үндэсний хөтөлбөр” үндэсний хөтөлбөрүүдийн 2018-2021 оны ХШҮ-ний тайлангуудаас харагдаж байна (Матриц 1.4).

Матриц 1. 4 Үндэсний хэмжээний бодлого, хөтөлбөрүүдийн тайлан, хяналт шинжилгээний тайланд хүйсээр ангилсан мэдээлэл тусгагдсан байдал

д/д	Бодлого, хөтөлбөрийн нэр	Хүйсээр ангилсан мэдээлэл тусгагдсан эсэх
1.	“Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарах зорилт, арга хэмжээний ХШҮ-ний тайлан, 2021	үгүй
2.	“Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарах хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцын ХШҮ-ний тайлан, 2021	үгүй
3.	“Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтийн ХШҮ-ний тайлан, 2021	үгүй
4.	“Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтийн ХШҮ-ний тайлан, 2021	үгүй
5.	“Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн ХШҮ-ний тайлан, 2021	үгүй
6.	“Монгол малчин үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн ХШҮ-ний тайлан, 2021	үгүй
7.	“Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” үндэсний хөтөлбөрийн 2021 оны хэрэгжилтэд хийсэн ХШҮ-ний тайлан, 2021	үгүй
8.	“Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийсэн ХШҮ-ний тайлан, 2021	үгүй

9.	“Жимс, жимсгэнэ” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хийсэн ХШҮ-ний тайлан, 2021	үндэсний хөтөлбөрийн явцад	үгүй
----	--	----------------------------	------

Тус салбарт гадаад орнууд болон олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж буй төслүүдийн хэрэгжилтийн ХШҮ-ний тайланд хүнтэй холбоотой мэдээллийг хүйсээр ангилан тусгаж, зарим тайланд хүйсийн тэгш байдлыг хангахад чиглэсэн дүгнэлт, зөвлөмж тусгасан байна (Матриц 1.3). Тухайлбал АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр ХХААХҮЯ-ны 2016-2021 онд хэрэгжүүлсэн “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил” төсөл нь АХБ-ны жендэрийн ангилалын системээр “жендэрийн тэгш байдлыг хангахад үр нөлөөтэй” гэсэн ангилалд багтсан ба эмэгтэйчүүдийг ур чадвар дээшлүүлэх сургалтад хамруулах, төслийн үр дүнд бий болсон ажлын байруудад эмэгтэйчүүдийг ажиллуулах замаар эмэгтэйчүүд төслөөс хүртэх үр шимийг нэмэгдүүлэхэд чиглэсэн Жендэрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлжээ. Мөн Дэлхийн банкны санхүүжилттэй “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх” төслийн Хүйсийн тэгш байдлыг хангах бодлогын хүрээнд эдийн засгийн үйл ажиллагаанд шийдвэр гаргахад эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, эмэгтэйчүүдийн ажил эрхлэх боломжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд төслийн явцын тайланд жендэрийн шалгуур үзүүлэлтүүдийг тусгах, зорилгоо хангахад чиглэж байна.

ХХААХҮ-ийн салбарын бодлого төлөвлөлт, ХШҮ-нд жендэрийн статистик мэдээлэл, жендэрийн шалгуур үзүүлэлтүүдийг ашиглахын тулд салбарт ажиллагсдын мэдлэг, ойлголт, чадавхыг сайжруулахад анхаарах нь чухал шаардлагатай байгаа нь судалгааны үр дүнгээс харагдлаа. Жишээлбэл Хэнтий аймгийн Биндэр сумын Орон нутгаас нэгтгэгдэх жендэрийн хөгжлийн үзүүлэлтийн тайланд төрийн болон төрийн бус байгууллагын удирдах ажилтнуудын тоо, хүйс, албан тушаалын зэрэглэлээр, жендэрийн сургалтанд хамрагдсан удирдах ажилтны тоо, хүйс, албан тушаалын зэрэглэлээр, орон нутгийн төсвөөс жендэрийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд төлөвлөсөн болон зарцуулсан санхүүжилтийн хэмжээ, сая төгрөгөөр гэсэн үзүүлэлтүүдийг гаргадаггүй ажээ.

Шигтгээ 1.4

Малчдын талаарх мэдээллийг хүйсээр ангилж гаргадаггүй. Хүйсээр ангилсан мэдээлэл ашиглах талаар өмнө нь бодож байгаагүй юм байна. Сүүлийн үед сумын аварга малчин шалгаруулахад өрхөөр нь шалгаруулдаг болсон. Өрх толгойлсон эмэгтэйчүүд сааль сүүгээ аваад сумын аварга саальчин болсон байдаг.

Ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэлээс, Сумын ХХААТ-ын мэргэжилтэн, Хэнтий аймаг

ХХААХҮ-ийн салбарт жендэрийн тэгш байдлыг хангахад донор орнууд, олон улсын байгууллагуудын хамтын ажиллагааны уялдаа, үр өгөөжийг сайжруулах

ХХААХҮ-ийн салбарт донор орнууд болон олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж буй төслүүдийн нэр, хэрэгжих хугацаа, төслийн зорилго, нийт

төсөв, санхүүжүүлэгчийн нэр, төслийн нэгжийн хаяг бүхий үндсэн мэдээллүүдийг багтаасан хуудас яамны вэб сайтад байршуулж, тухайн төслийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл бүхий вэб хуудастай холбожээ. Түүнчлэн эдгээр төслийн явцад жил бүр хийгддэг ХШҮ-ний тайланг байршуулсан нь судалгаатай холбоотой мэдээлэл авахад чухал ач холбогдолтой байлаа.

Тухайлбал, Европын холбоо болон ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яам (BMZ)-ны хамтарсан санхүүжилттэйгээр Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ), НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны хамтран хэрэгжүүлж буй “Монгол улсад хүнсний тогтолцоо, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд шинэлэг, тогтвортой, ландшафтын түвшний менежментийг хэрэгжүүлэх чадавхыг нэмэгдүүлэх” зорилготой “Хөдөө аж ахуйн менежмент, экосистемийн тогтвортой байдлыг хангах” (СТРИЙМ), НҮБ-ийн ХААБ-ын төсөл зэрэг томоохон төслүүд хэрэгжиж байна.

ХХААХҮ-ийн салбарын бодлогод “Хөдөөгийн эмэгтэйчүүд, охидын аж байдлыг сайжруулах НҮБ-ын тогтоол”-ыг хэрэгжүүлэх үндэсний болон бүс нутгийн түвшинд манлайлах чадавхыг бэхжүүлэх, түүнчлэн өрх толгойлсон малчин, тариаланч эмэгтэйчүүдийг чадавхжуулах төслийг үндэсний түвшинд хэрэгжүүлэх зорилт дэвшүүлсэн. Бодлогын хэрэгжилтийн эхний үе шатанд Гадаад харилцааны яамны Олон талт хамтын ажиллагааны газрын зөвшөөрлөөр “Хөдөөгийн эмэгтэйчүүд, охидын аж байдлыг сайжруулах НҮБ-ын тогтоол”-ыг орчуулан, англи, монгол хэлээр хэвлэн түгээх, тогтоолын хэрэгжилтийн талаар “Мал аж ахуйн салбар дахь жендэрийн дүн шинжилгээ” зэрэг сургалт, хэлэлцүүлэгт танилцуулах зэрэг бэлтгэл ажлууд хийгдэж байна.

Хоёр. Орон нутгийн бодлого, хөтөлбөр дэх уялдаа, бүтэц, мэдээлэл

2022 оны байдлаар Монгол Улсын 21 аймаг жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрөө боловсруулан, хэрэгжүүлж байна. Үүнээс бид үнэлгээний зорилтот аймаг болох Архангай, Хэнтий аймгийн 2020 онд батлагдсан дэд хөтөлбөр ХХААХҮ-ийн салбарын жендэрийн бодлоготой хэрхэн уялдаж байгаа, ХАА дахь жендэрийн асуудалд анхаарсан эсэх, малчин, тариаланчдад чиглэсэн эсэх, тус салбарт шууд болон ерөнхийлөн хамаарах арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн эсэхийг авч үзлээ.

Дээрх хөтөлбөрүүдэд ХАА, тэр дундаа МАА, газар тариалангийн үйлдвэрлэл дэх орон нутгийн онцлогийг харгалзсан асуудал дэвшүүлээгүй, зорилтот бүлэгт малчин тариаланчдыг тусгайлан анхаараагүй, малчин, тариаланч эрэгтэй, эмэгтэйчүүдэд шууд чиглэсэн ямар нэг арга хэмжээ тусгаагүй байна. ХХААХҮ-ийн салбарын жендэрийн бодлого дахь малчин, тариаланчдад хамаарах ажлын нөхцөлийг сайжруулахад чиглэсэн ХАБЭА-г сайжруулах, ажилтнуудын нийгмийн хамгааллыг сайжруулах, эмэгтэй малчин, тариаланчдын ажиллах нөхцөл, ур чадварыг сайжруулах арга хэмжээ тусгагдаагүй, харин ерөнхий утгаараа “жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх ажил” тусгагдсан онцлогтой байна. 2021 онд Архангай аймаг жендэрийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, хэрэгжилтийг сайжруулахад чиглэсэн дүгнэлт, зөвлөмжийг гаргажээ.

Орон нутгийн жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийн уялдаа

ХХААХҮ-ийн жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлогын орон нутаг дахь хэрэгжилтийг эрчимжүүлэхэд салбарын агентлаг, байгууллага, нэгж чухал үүрэг гүйцэтгэх шаардлагатай нь харагдаж байна.

Матриц 2. 1 ОНЖДХ-т малчин эрэгтэй, эмэгтэйчүүдийн асуудал тусгасан эсэх
(Архангай, Хэнтий аймаг)

	Архангай	Хэнтий
ОНЖДХ-ийн үндэслэл хэсэгт ХАА, МАА, газар тариалангийн үйлдвэрлэлд жендэрийн тэгш байдлыг хангах хэрэгцээ шаардлага буйг анхаарсан эсэх	Үгүй	Үгүй
ОНЖДХ-ийн зорилтот бүлэгт малчин эрэгтэй, эмэгтэйчүүд багтсан эсэх	Үгүй	Үгүй
ОНЖДХ-ийн зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд малчин, тариаланч эрэгтэй, эмэгтэйчүүдэд шууд чиглэсэн зорилт, арга хэмжээ бий эсэх	Үгүй	Үгүй
ХХААХҮ-ийн салбарын жендэрийн бодлоготой уялдах байдал		
Салбарын хөдөлмөр эрхлэлт дэх ХАБЭА-г сайжруулах арга хэмжээ	Үгүй	Үгүй
Салбарын нийгмийн хамгааллыг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ	Үгүй	Үгүй
Ажлын байран дахь жендэрийн ялгаварлан гадуурхалт, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилэн сэргийлэх арга хэмжээ	Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх ажил	Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх ажил
Эмэгтэй малчин, тариаланчдын ажиллах нөхцөл, ур чадварыг сайжруулах арга хэмжээ	Үгүй	Үгүй
Эх сурвалж: 1. Архангай аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлын 2020 оны 09 сарын 02-ны өдрийн 40 дугаар тогтоолын хавсралт: Архангай аймгийн жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр (2020-2024) 2. Хэнтий аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлын 2020 оны 03 сарын 05-ны өдрийн 15 дугаар тогтоолын хавсралт: Хэнтий аймгийн жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр (2020-2021)		

Орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөрт тусгагдсан дараах арга хэмжээ нь ХХААХҮ-ийн салбарын жендэрийн бодлогын хэрэгжилтийг дэмжихэд эерэг нөлөөтэй гэж үзэж байна. Үүнд:

Архангай аймгийн дэд хөтөлбөр:

- 3.1.6 Жендэрийн статистик мэдээллийн санг салбар бүрээр бүрдүүлэн, бодлого төлөвлөлтөд ашиглах
- 3.1.7 Жендэрийн тэгш байдлыг хангах ажлыг сум, баг, байгууллагын түвшинд хөхиүлэн дэмжиж, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх
- 3.3.3 Жендэрийн хэвшмэл ойлголтыг арилгах, орон нутгийн хөгжилд эрэгтэй, эмэгтэйчүүд, нийгмийн бүлгүүдийн оролцоог хангахад залуучуудын манлайллыг дэмжих зэрэг болно.

Хэнтий аймгийн дэд хөтөлбөр:

- 1.1 Жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт, төсөвлөлтийг орон нутагт хэрэгжүүлэх чадавхыг бүрдүүлж, салбар хорооны үйл ажиллагааг өргөжүүлэх
- 1.2 Орон нутгийн нийгэм, эдийн засгийн үзүүлэлтэд жендэрийн нөхцөл байдлыг харуулсан суурь судалгаа танилцуулах

1.3 Жендэрийн асуудлаарх статистик мэдээллийн нэгдсэн сантай болж, шийдвэр гаргагч нарыг мэдээллээр хангах

3.1 Байгууллагын өдөр тутмын хөдөлмөрийн харилцаа, ажиллах нөхцөлийг зохицуулах бодлогын баримт бичигт жендэрт суурилсан аливаа хүчирхийллээс сэргийлэх, таслан зогсоох, гомдлыг шийдвэрлэх механизмыг суулгах

4.1 Эмэгтэйчүүдийн манлайллыг дэмжих оролцоонд суурилсан сургалтыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах

Орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөрийн хэрэгжилт ба салбарын жендэрийн бодлого

Орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөрийн хэрэгжилт Ковид-19 цар тахлын үеийн хоригтой холбоотойгоор саарсан болох нь Архангай аймгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлангаас харагдаж байна. Гэхдээ дээр дурдсан ХХААХҮ-ийн салбарын жендэрийн бодлогын хэрэгжилтийг дэмжихэд чухал үүрэгтэй арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд тус аймаг зохих түвшинд анхааран ажиллаж байгаа бөгөөд тайлангаас харахад салбар дундын болон орон нутгийн нэгжийн удирдлага хоорондын хамтын ажиллагаа, зохицуулалт үгүйлэгдэж байгаа нь ажиглагдлаа.

Матриц 2. 2 ОНЖДХ-ийн хэрэгжилт, аймгаар

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРТ БАРИМТЛАХ
ЖЕНДЭРИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Архангай		Хэнтий	
Арга хэмжээ	Хэрэгжилт ба анхаарах зүйлс	Арга хэмжээ	Хэрэгжилт ба анхаарах зүйлс
3.1.6 Жендэрийн статистик мэдээллийн санг салбар бүрээр бүрдүүлэн, бодлого төлөвлөлтөд ашиглах	Жендэрийн орон нутгийн 63 статистик үзүүлэлтийг жил бүр гаргасан. Засаг даргын дэргэдэх аентлагийн дарга нартай хийх үр дүнгийн гэрээнд жендэрийн заалтыг жил бүр тусгах	1.1 Жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт, төсөвлөлтийг орон нутагт хэрэгжүүлэх чадавхыг бүрдүүлж, салбар хорооны үйл ажиллагааг өргөжүүлэх: Бүх сумдад дэд салбар хороо байгуулах	2021 оны ХШҮ-ний тайлан бүх суманд Жендэрийн дэд салбар хороог байгуулж, дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг гарган ажилласан гэж тайлагнасан боловч зарим сумдад энэ хэрэгжээгүй байна.
3.1.7 Жендэрийн тэгш байдлыг хангах ажлыг сум, баг, байгууллагын түвшинд хөхүүлэн дэмжиж, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх	Хэрэгжих хугацаа нь болоогүй	1.2 Орон нутгийн нийгэм, эдийн засгийн үзүүлэлтэд жендэрийн нөхцөл байдлыг харуулсан суурь судалгаа танилцуулах	Жендэрийн суурь судалгаа "Залуу манлайлагч" ТББ-аг гүйцэтгүүлж, аймгийн ЗДЗ ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулсан.
3.3.3 Жендэрийн хэвшмэл ойлголтыг арилгах, орон нутгийн хөгжилд эрэгтэй, эмэгтэйчүүд, нийгмийн бүлгүүдийн оролцоог хангахад залуучуудын манлайллыг дэмжих	Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах чиглэлээр сургалт, мэдээллийн ажлууд зохион байгуулсан	1.3 Жендэрийн асуудлаарх статистик мэдээллийн нэгдсэн сантай болж, шийдвэр гаргагч нарыг мэдээллээр хангах	2021 оны байдлаар 19 төрлийн статистик үзүүлэлт сум бүрээр гаргасан боловч хүйсээр ангилсан тоон мэдээлэл хангалтгүй байна.
		3.1 Байгууллагын өдөр тутмын хөдөлмөрийн харилцаа, ажиллах нөхцөлийг зохицуулах бодлогын баримт бичигт жендэрт суурилсан аливаа хүчирхийллээс сэргийлэх, таслан зогсоох, гомдлыг шийдвэрлэх механизмыг суулгах	Аймаг, сумдын нутгийн удирдлагын байгууллагууд, ХДЖ-д жендэрт суурилсан аливаа хүчирхийллээс сэргийлэх, таслан зогсоох гомдлыг шийдвэрлэх механизмыг тодорхой бүс ерөнхий байдлаар тусгасан хэвээр байна.
<p>Эх сурвалж:</p> <ol style="list-style-type: none"> 1. Архангай аймгийн жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр (2020-2024)-д хийсэн ХШҮ-ний тайлан, 2021 2. Хэнтий аймгийн жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх ХШҮ-ний тайлан, 2022 			

Аймаг сумдад ХХААХҮ-ийн салбарын жендэрийн бодлогыг хэрэгжүүлэх албан ёсны бүтэц бий болгох нь ихээхэн чухал үүрэгтэйг дээр дурдсан. Бид ИМПАКТ төслийн

зорилтот сумдаас энэ талаар тодруулсан бөгөөд бидний судалгаагаар сумдын түвшинд аль ч аймагт тус жендэрийн асуудлыг хариуцах үүргийг тусгайлан хүлээсэн субъект байхгүй, тус чиг үүргийг ажилтнуудад сэлгэн хариуцдаггүй, ХХААХҮЯ-аас ямар нэгэн удирдамж чиглэлээр хангаж ажиллаагүй байна. Мөн үнэлгээнд хамрагдсан бүх сумдын ХХАА-н тасгийн ажилтнууд бүгд (100%) салбарын жендэрийн бодлогын талаар огт мэдээлэлгүй байв (Матриц 2.3). Энэ бүгд нь салбарын жендэрийн бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн санхүүжилт дутмагийн улмаас салбар дотооддоо тус бодлогыг хэрэгжүүлэх бүтцийг бүрэлдэн тогтоож чадахгүй байгаа, салбарын орон нутгийн түвшин дэх удирдлагын хүсэл зориг чухал үүрэгтэй болохыг харуулж байна.

Матриц 2. 3 Салбарын жендэрийн бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх бүтэц бүрэлдсэн эсэх, бодлогын талаарх мэдлэг

Аймаг	Сум	Сумын ХХАА-н тасагт жендэрийн асуудал хариуцсан хүн бий эсэх	Ажилт-нууд сэлгэн хариуцдаг эсэх	ХХААХҮЯ-аас ажлын удирдамж өгсөн эсэх	Жендэрийн бодлогыг мэддэг эсэх
Архангай	Жаргалант	байхгүй	үгүй	үгүй	мэдэхгүй
Архангай	Цэцэрлэг	байхгүй	үгүй	үгүй	мэдэхгүй
Архангай	Эрдэнэбулган	байхгүй	үгүй	үгүй	мэдэхгүй
Хэнтий	Биндэр	байхгүй	үгүй	үгүй	мэдэхгүй
Хэнтий	Мөрөн	байхгүй	үгүй	үгүй	мэдэхгүй
Хэнтий	Хэрлэн	байхгүй	үгүй	үгүй	мэдэхгүй

Эх сурвалж: ОХШҮ-ний ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэл

Орон нутгийн түвшинд салбарын жендэрийн бодлогын хэрэгжилтийг хангах үүрэг хариуцлага албан бусаар буюу хэн нэгэн албан тушаалтанд давхар хавсруулах байдлаар үүрэгжүүлдэг, аймгийн ЖСХ-ны ОНЖДХ-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй уялдуулдаггүй, төлөвлөж төсөвлөдөггүй нь ХХААХҮС-ын жендэрийн бодлогын хэрэгжилтийг сулруулж, дээд шатны байгууллагадаа тайлагнах төдийгөөр хязгаарлах нөхцөл байдалтай байгааг зарим мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлагын дүн харуулж байна.

Бид судалгаагаар сумдын түвшинд жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлдэг эсэхийг тодруулав. Үнэлгээ явагдсан зорилтот сумдын алинд ч жендэрийн эрх тэгш байдлыг тусгай төлөвлөгөө гаргаж ажилладаггүй, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Сум хөгжүүлэх стратеги төлөвлөгөө зэрэг холбогдох бодлогын баримт бичигт зарим үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан байна (Матриц 2.4).

Архангай аймгийн Жаргалант сум жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хороо байгуулах санаачилга гаргасан ч бусад сумдад энэ санаачилга дэлгэрээгүй байна. Тус аймгийн сумдын бодлогын баримт бичигт нийтлэг байдлаар дараах хоёр ажил тусгагджээ. Тодруулбал:

- Хөдөөгийн эрэгтэй, эмэгтэйчүүдийн, тэр дундаа эхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах,
- Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх.

Тухайн сумын онцлогтой холбогдуулан хөдөөгийн эмэгтэйчүүдийн орлогожуулах, амьжиргааг дээшлүүлэх, бодлого, шийдвэрт оролцох оролцоог нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, баялгийн тэгш шударга хуваарилалтад анхаарсан арга хэмжээг тусгасан нь сайшаалтай байна.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн бодит хэрэгжилтийг бид судаллаа. Архангай аймгийн сумдын жишээнээс харахад хөдөөгийн эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах болон жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа их, бага хэмжээгээр хэрэгжиж эхэлсэн бол сумдын онцлог бүхий үйл ажиллагаанууд хэрэгжиж эхэлсэн, намар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байгаагаас сумдын эрх бүхий байгууллага, албан тушаалтны хэрэгжүүлэх бодлогын баримт бичигт жендэрийн эрх тэгш байдлыг хангахад ач холбогдолтой арга хэмжээг тусгах нь илүү үр дүнтэй болохыг харуулж байна. Иймд ХХААХҮЯ-аас жендэрийн бодлогын хэрэгжилтийг хангахын тулд сумдын өөрийн бүтцээрээ дамжуулан эдгээр баримт бичигт төлөвлөгдсөн арга хэмжээг тусгуулахад анхаарч ажиллах шаардлагатай байна. Түүнчлэн, тухайн орон нутагт ОУБ-аас дэмжин хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр нь жендэрийн эрх тэгш байдлыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлж байгааг Матриц 2.5 харуулж байна. Үүнтэй холбоотойгоор салбарын хэмжээнд хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийг салбарын жендэрийн бодлоготой уялдуулах зохицуулалтыг яамны зүгээс хийж чадвал бодлогын хэрэгжилтийг бодит үйл хэрэг болгоход ихээхэн ач холбогдолтой байж чадна гэдэг нь харагдаж байна.

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРТ БАРИМТЛАХ
ЖЕНДЭРИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Матриц 2. 4 Зорилтот сумдын бодлогын баримт бичиг дэх уялдаа

Сонирхсон үзүүлэлт	Архангай	
	Жаргалант	Цэцэрлэг
Малчин, тариаланч эрэгтэй, эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах	- “Гэрийн эмч” загвар төслийг хэрэгжүүлэх Багийн эмчийг чадавхжуулж, тоног төхөөрөмжөөр хангах. - Эх, хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртэмжийг нэмэгдүүлэх, эхийн амрах байрыг тохижуулах	Эх, хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртэмжийг нэмэгдүүлэх
Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх, хүчирхийллийг арилгах, урьдчилан сэргийлэх	- Гэр бүлийн гишүүн бүрд гэр бүлийн боловсрол олгох, - Хүүхэд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эсрэг чиглэсэн гэмт хэрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, - Ялгаварлал, бэлгийн дарамт, хүчирхийллийг ажлын байр, олон нийт, гэр бүлийн бүх орчинд таслан зогсооход чиглэсэн арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх	- Хүүхэд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эсрэг чиглэсэн гэмт хэрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх
Малчин, тариаланч эмэгтэйчүүдийн орлогыг нэмэгдүүлэх	-“Малчин эмэгтэйчүүд ба аюулгүй хүнс” арга хэмжээг хэрэгжүүлж, сүү, цагаан идээний эрүүл ахуй, ариун цэвэр, чанар, стандартыг дээшлүүлж зах зээлийн үнэлэмжийг нэмэгдүүлэх	
Баялгийн тэгш хуваарилалтыг дэмжих	Нэг айл, нэг өвөлжөө – 10 га газар” арга хэмжээ хэрэгжүүлэх	
Нийгмийн бүлгүүдийг эрх мэдэлжүүлэх, оролцоог нэмэгдүүлэх		Ахмад, эмэгтэйчүүд, ИНБ, зорилтот бүлгүүдийн хүсэл сонирхол, эрх ашгийг төрийн болон орон нутгийн шийдвэрт тусгуулах зорилгоор Иргэний танхим байгуулж, үйл ажиллагаа эрчимжүүлэх
Орон нутагт ЖЭТБХ салбар зөвлөл/хороо байгуулсан эсэх	Тийм	Үгүй
Эх сурвалж: - Баримт бичгийн шинжилгээний мэдээлэл - Ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэл		

Матриц 2. 5 Бодлогын баримт бичиг дэх арга хэмжээний хэрэгжилтийн байдал, 2021 болон 2022

	Жаргалант	Цэцэрлэг	Архангай
Малчин, тариаланч эрэгтэй, эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах	Хэрэгжиж эхэлсэн	Хэрэгжиж эхэлсэн	
Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх, хүчирхийллийг арилгах, урьдчилан сэргийлэх	- Мэдлэг ойлголт сайжруулах сургалт зохион байгуулсан Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн болон үйлдэж болзошгүй иргэдийн судалгааг гарган ажилласан Хүчирхийлэл үйлдэгч 3 иргэнийг хуулийн сургалтад хамруулсан.	Хамтарсан багийн үйл ажиллагааг тогтворжуулан хөгжүүлэхэд анхааран ажиллаж байна.	
Малчин, тариаланч эмэгтэйчүүдийн орлогыг нэмэгдүүлэх	- 2022 оны төлөвлөлтөд туссан.		
Баялгийн тэгш хуваарилалтыг дэмжих	- Судалгаа хийх шатанд хэрэгжиж байгаа.		
Нийгмийн бүлгүүдийг эрх мэдэлжүүлэх, оролцоог нэмэгдүүлэх		Иргэний танхим байгуулж, тохижуулсан	
Бодлогын баримт бичигт тусаагүй бусад холбогдох ажил	- Импакт төслийн Жендэрийн мэдлэг ойлголтыг сайжруулах сургалт - Эмэгтэйчүүдийн бүлэг байгуулж чадавхжуулах үйл ажиллагаа - Эмэгтэйчүүдийн орлого, ӨТЭ-ийн амьжиргааг дээшлүүлэх үйл ажиллагаа	- Импакт төслийн Жендэрийн мэдлэг ойлголтыг сайжруулах сургалт - Эмэгтэйчүүдийн бүлэг байгуулж чадавхжуулах үйл ажиллагаа	
<i>Эх сурвалж: Баримт бичгийн шинжилгээний мэдээлэл</i>			

Бүлэг 3. Мал аж ахуйн салбарын хүний нөөцийн хөгжил, эмэгтэйчүүдийн оролцоо

Салбарын жендэрийн бодлогод хүний нөөцийн бэлтгэх тогтолцоог жендэрийн мэдрэмтэй хөгжүүлэх, мал аж ахуйн салбарт ажиллагч эмэгтэйчүүдийн ажиллах нөхцөл, ХАБЭА, нийгмийн хамгааллыг сайжруулах, зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөө аж ахуйн зохистой дадлыг хүйсийн ялгаатай хэрэгцээнд нийцүүлэн эзэмшүүлэх, малчин гэр бүлийг дэмжих, залгамж халааг бэлтгэх нийгэм соёл, эдийн засгийн цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх зорилтуудыг дэвшүүлсэн.

МАН-н салбарт “Монгол мал үндэсний хөтөлбөр” (2010-2021), “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого” (2009-2020), “Монгол малчин” үндэсний хөтөлбөр (2020-2024) зэрэг бодлогыг хэрэгжүүлж байна. “Монгол мал үндэсний хөтөлбөр” (2010-2021)-ийг 2 үе шаттайгаар хэрэгжүүлж байгаа бөгөөд жендэрийн эрх тэгш байдлыг хангахтай холбоотой, тодруулбал, МАН-н хүний нөөцийг бүрдүүлэх, мэргэжлийн чадавхыг бэхжүүлэхтэй холбоотой зарим арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байна. Гэвч эдгээр арга хэмжээнд жендэрийн үзэл баримтлал нэгтгэгдээгүй, гарч буй үр дүнг хүйсээр

ангилсан мэдээллээр харуулаагүй байна. Малчин эмэгтэйчүүдийн чадавхыг хөгжүүлэх, ялангуяа жендэрийн ялгаатай хэрэгцээнд чиглэх санаачилга ОУБ-аас санхүүжүүлж буй төсөл, арга хэмжээнд түлхүү ажиглагдаж байна.

“Төрөөс малчдын талаар баримтлах бодлого” нь малчдыг орон нутагтаа тав тухтай ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, ядуурлаас ангид байлгах, тэдэнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын баталгаа бий болгоход чиглэсэн эрх зүй, эдийн засаг, бизнесийн таатай орчныг бүрдүүлэх; малчин өрхийн эдийн засгийн үндэс болсон мал аж ахуйн үйлдвэрлэлийн зохион байгуулалтыг сайжруулж бүтээмж, чанар, үр ашгийг дээшлүүлэх, бүтээгдэхүүн борлуулах зах зээлийн оновчтой тогтолцоо бий болгох; малчдын өөрөө өөртөө туслах, өөрөө өөрийгөө удирдах иргэний нийгмийн бүтцийг бий болгон хөгжүүлэхийг дэмжих, боловсрол, мэдлэг чадварыг дээшлүүлэх, тусгай мэргэжил эзэмшүүлэх, малчдад үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах замаар амьдралын дадал, заншлыг өөрчлөх зорилтуудыг хэрэгжүүлэхэд анхаарсан. Эдгээр нь эрэгтэй, эмэгтэй малчдад тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлснээрээ давуу талтай бөгөөд бодлогын хэрэгжилтийн тайлан хүйсээр ангилсан мэдээлэлд тулгуурлаагүй тул нийгмийн байр сууриараа ялгаа бүхий эрэгтэй, эмэгтэй малчдад ямар үр дүн, үр нөлөө авчирсан болохыг харах боломжгүй байна. Тус бодлогын төлөвлөлтөд жендэрийн үзэл баримтлалыг тусгаагүйтэй, ХШҮ-нд жендэртэй хамаарах шалгуур үзүүлэлт багтаагүй байна. Энэ нь тус бодлогын баримт бичиг салбарын жендэрийн бодлого батлагдахаас өмнө төлөвлөгдөн хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой байж болох юм.

Матриц 3. 1 ХХААХҮЯ “Монгол мал үндэсний хөтөлбөр” (2010-2021)-ийн хэрэгжилт, 2020

	Хэрэгжилт	Оролцогч тал	Хүйсээр ангилсан мэдээлэл
1.3.1. Малчдыг мэдлэгжүүлэх олон залуу халааг бэлтгэхэд чиглэгдсэн зайн сургалтыг давтамжтай явуулах	"Малчин мэргэжлийн ажил мэргэжлийн" стандарт батлуулсан. Сургалтын хөтөлбөр боловсруулсан 125 малчинд сургалт зохион байгуулсан. Ноолуур бэлтгэн нийлүүлэгч 1500 эмэгтэйг сургалтад хамруулсан	Тогтвортой ноос, ноолуурын эвсэл Мэргэжлийн боловсрол сургалтын үнэлгээ, мэдээлэл арга зүйн төв Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв	Үгүй, гэхдээ зарим арга хэмжээнд эмэгтэй оролцогчийн мэдээлэл бүхий
1.3.3. Мал зүйн мэргэжилтэн бэлтгэх, давтан сургах сургалтын төлөвлөгөөг шинэчлэх, мэргэжилтэнг орон нутаг, хувийн хэвшлийн нэгжийн захиалгаар бэлтгэх тогтолцоог дэмжин хөгжүүлэх	ХААИС-д 2019-2020 оны хичээлийн жилд тусгай дунд мэргэжлийн хүмүүст мал зүйч бакалаврын боловсрол олгох хавсарга, эчнээ хөтөлбөр 38 хүн хамрагдаж суралцсан. “Бог малын ангилагч, шинжээч бэлтгэх” сургалтаар 9 аймаг, нийслэлийн 28 мал зүйч хамрагдаж ангилагч, шинжээч болсон.	ХААИС	Үгүй

1.3.7. Орон нутгийн санаачилгад үндэслэн малын нөхөн үржүүлэгийн техникч, мэргэжилтний хүрэлцээг нэмэгдүүлэх	МСҮТ-ээр дамжуулан бод, бог малын зохиомол хээлтүүлгийн үржүүлгийн техникч бэлтгэх сургалтыг зохион байгуулав. Амжилттай суралцсан зарим аймгийн мэргэжилтнүүдийг бод, бог малын зохиомол хээлтүүлгийн иж бүрэн багаж төхөөрөмжөөр хангав.	МСҮТ болон бусад	Үгүй
Эх сурвалж: Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан, 2021			

Энэхүү бодлогын үргэлжлэл болох “Монгол малчин” үндэсний хөтөлбөрийг 2020 оноос хойш хэрэгжүүлж эхлээд байна. Тус баримт бичигт малчдыг мэдлэгжүүлэх, мэдээллээр хангах аяныг өрнүүлж, малчдын мал маллах, аж ахуй эрхлэх арга барил, мэдлэг, чадавхыг сайжруулах, малчдын залуу халааг бэлтгэх, энэ хүрээнд “залуу малчид, гэрээт болон туслах малчдад зориулсан сургалтын хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх, туршлага судлуулах” арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Мөн малчин гэр бүл сургууль хичээллэх үеэр хоёр тусдаа амьдрах болсон нь ажиллах хүчний дутмаг байдал, эмэгтэйчүүдийн ажиллах хүчний идэвхэд сөргөөр нөлөөлж байгаа төдийгүй жендэрт хамаарах бусад асуудлыг бий болгоход нөлөөтэй байгаа тул “малчдын хүүхэд бага ангид шинээр элсэн суралцахтай холбогдон малчин өрхөд үүсч байгаа хүндрэлийг багасгахад чиглэгдсэн шинэ арга барилыг нэвтрүүлэх” гэсэн арга хэмжээг төлөвлөжээ. Эдгээр арга хэмжээ нь салбарын жендэрийн бодлоготой уялдаж байгаа боловч тус бодлогоор хөндсөн асуудал, зорилт, арга хэмжээ, ХШҮ-ний шалгуур үзүүлэлтүүдэд жендэрийн үзэл баримтлал нэгтгэгдсэн баримт нотолгоо байсангүй. Өөрөөр хэлбэл, эрэгтэй, эмэгтэй малчдын ялгаатай хэрэгцээг тусгаагүй бодлого болсон бөгөөд салбарын дотоод дахь бодлого төлөвлөлтөд жендэрийн үзэл баримтлалыг нэгтгэх ажил хангалттай хэрэгжихгүй байгааг илтгэх юм.

МАН салбарын хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах

Орон нутгийн түвшинд салбарын жендэрийн бодлогод анхаарсан МАН-н хүний нөөцийг бүрдүүлэх, чадавхжуулах, ХАБЭА-н чадавхыг бэхжүүлэх чиглэлд хэрхэн анхаарч буйг үнэлгээгээр сонирхон судлав. Зорилтот орон нутагт салбарын ажилтны ажил мэргэжлийн байр суурьт хамаарах хүйсээр ангилсан мэдээлэл харьцангуй дэвшилттэй байна. Орон нутагт МАН-н нарийн мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай ч сум орон нутгаас мэргэжилтэй боловсон хүчнээ бэлтгэхэд дорвитой анхаарахгүй байгаа нь ажиглагдлаа. “Залуу малчдын жендэрийн дүн шинжилгээ” (ЖҮХ, АХБ, 2021)-ний үр дүнг дахин баталгаажуулж, залуу малчин бэлтгэх, МАН-н мэргэжилтэнг бэлтгэх төлөвлөлтөд жендэрийн мэдрэмжтэй хандлага дутагдаж байгаа нь зорилтот орон нутагт илрэв. Түүнчлэн, МАН-н салбарт ХАБЭА-н хэм хэмжээ, сургалт, чадавхжуулах үйл ажиллагаа бараг хийгдэхгүй, анхаарлын гадна үлдэж байна. Харин бүх сумдад малчдад “цаг агаарын аюултай үзэгдэл”-ийн мэдээллийг гар утасны мессэж, орон нутгийн ХМХ-ээр дамжуулдаг туршлага бий болжээ.

Матриц 3. 2 МАН-н мэргэжилтэнг бэлтгэх, ХАБЭА-н талаар хэрэгжүүлж буй үйл ажиллагаа (жендэрийн мэдрэмжтэй байдал)

Аймаг	Сум	Орон нутгийн МАН-н мэргэжилтэнг бэлтгэхэд хүйсээр ангилсан мэдээлэл ашигладаг, жендэрийн мэдрэмжтэй ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх ажил хийгддэг эсэх	МАН-н салбарт ХАБЭА-ыг хэрхэн мөрдүүлж ажилладаг вэ? ХАБЭА-н нөхцөлийг сайжруулах чиглэлээр ямар арга хэмжээ авдаг вэ? Төсөв хуваарилдаг уу, хуваарилсан төсөв хангалттай хүрэлцдэг үү?
-------	-----	--	---

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРТ БАРИМТЛАХ
ЖЕНДЭРИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Архангай	Жаргалант	Үгүй	Үгүй, төсөв хуваарилдаггүй
Архангай	Цэцэрлэг	Үгүй. Малын эмчийн тоо дутагдалтай хэвээр байгаа. Мэргэжлийн мал зүйч, зоо техникч байхгүй. Салбар болон орон нутгийн зүгээс мэргэжилтнээ бэлтгэх, мэргэжил сонголтод нөлөөлөх талаар анхаарах нь сул. Ямар хүйсийн хүн байлгах талаар анхаардаггүй.	ХАБЭА-н дүрэм гэж байгаа байх. Энэ чиглэлд төсөв мөнгө хуваарилдаггүй
Архангай	Эрдэнэбулган	Үгүй	ХАБЭА-д хамаарах хэм хэмжээ байдаггүй
Хэнтий	Биндэр	Мэдэхгүй	Жишиг аян гэх мэт арга хэмжээ явагддаг, төлөвлөгөөт үзлэг шалгалт хийгддэг. Ерөнхий ХАБЭА-н баримт бичгүүд бий. ХАБЭА чиглэлээр “Хүний төлөө академи” сургалтад хамрагдсан.
Хэнтий	Биндэр	Үгүй	Мэдээлэл муутай. Мал хувьд байдаг болохоор я малчдад зориулсан заавар зөвлөгөө өгдөггүй.
Хэнтий	Мөрөн	Мэдэхгүй	ХАБЭА-н талаар явуулах баримт бичиг байхгүй. Ямар хувцас өмсөх, хаанаас салхитай үед цацаа бороотой бол гэх мэт зөвлөгөө өгдөг. Зохистой дадлын ном, стандарт байдаг, хүмүүст гарын авлага тараадаг.
Хэнтий	АЗДТГ	Энэ талаарх ажил хомс хийгддэг.	МАН-н салбарт хувийн хэвшил, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн оролцоо өндөр байдаг тул төрийн оролцоо хангалтгүй.

Эх сурвалж: Ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэл

Залуу малчин гэр бүлийг бэлтгэх, дэмжих үйл ажиллагаа бүх орон нутагт малжуулах төслөөр хязгаарлаж байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд “малжуулах” болон “туслах малчин” хөтөлбөрүүдийг батлан хэрэгжүүлж байгаагаас “малжуулах хөтөлбөр”-ийн хэрэгжилт тогтвортой үргэлжилж байгаа нь судалгаагаар харагдлаа. Үнэлгээнд хамрагдсан орон нутгийн ажилтнуудын мэдээлснээр малжуулах хөтөлбөрт хамрагдаад, зээлээ эргэн төлж чадаагүй эрсдэлтэй зээлдэгчийн төрөлд орсон зөвхөн нэг тохиолдол гарсан байна. “Эрэгтэй, эмэгтэй залуу малчдын амьдрал ахуй дахь жендэрийн дүн шинжилгээ”-ээр (ЖҮХ, АХБ, 2021) тус хөтөлбөрийн зээл эргэн төлөгдөх хугацаа хэт богино байгаа нь зээлийн үр шимийг илүү тогтвортой хүртэхэд хүндрэл болж байгааг илрүүлсэн. Цөөн малтай залуу малчин өрхийн амьжиргааг дээшлүүлэхэд малжуулах төсөл чухал үүрэгтэй ч үр нөлөөг сайжруулж, зээл эргэн төлөх хугацааг сунгах шаардлага буйг онцолж байв. Судлагдсан орон нутагт малчдын дундаж нас ахиж, залуу малчдын хувийн жин бага байгаа энэ тохиолдолд “Туслах малчин”-ы хөтөлбөр чухал үүрэгтэй. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт уг бодлого тусгагдсан ч зорилтот орон нутгийн алинд ч хэрэгжиж эхлээгүй байгаа ба үүнд дараах хүчин зүйлс нөлөөлжээ. Үүнд:

Нэгд, Хөдөлмөрийн тухай хуульд орсон өөрчлөлт нь туслах малчин хөтөлбөрийг ажил олгогч малчин хэрэгжүүлэхэд хүндрэлтэй болсон байна. Учир нь, туслах малчдад хөдөлмөрийн хөлсний доод түвшний цалин хөлс олгохоор заасан нь туслах малчны хэрэгцээ байгаа боловч хэт олон биш малтай өрхөд илүү хүнд тусаж байгаа ажээ.

Хоёрт, Туслах малчныг ажиллуулах хэрэгцээ тухайн орон нутагт бий эсэхийг тандах шатандаа байна. Эрэлт хэрэгцээ их байгаа тул хэрэгжих боломжтой гэж үзэж байна.

Дээрх хөтөлбөрүүд малчин гэр бүлийг дэмжихэд чиглэсэн бөгөөд ганц бие, өрх толгойлсон эрэгтэй эсвэл эмэгтэйд чиглээгүй. Тиймээс ганц бие, өрх толгойлсон эрэгтэй эсвэл эмэгтэй малчны амьжиргааг ахиулахад анхаарсан бодлогын арга хэмжээ үгүйлэгдэж байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйг сайжруулах

Мал аж ахуйн салбарт ХАБЭА-г сайжруулах чиглэлээр бодлого, үйл ажиллагааны хэрэгжилт хангалтгүй байна. Зорилтот сумдын малчидтай хийсэн ярилцлагад МАА-н хөдөлмөрийн үйл ажиллагаанд ХАБЭА-н шаардлага тавигдах ёстой, малчдыг мэдлэгжүүлэх, зохистой дадал хэвшилтэй болгоход анхаарах ёстой гэдэгтэй бүгд санал нийлж байв. Нэгдлийн үед малчид, саальчдыг ХАБЭА-н хувцас хэрэгслээр хангадаг, сүү, цагаан идээ бэлтгэх, мал төллөх үе, өвлийн улиралд өмсөх хувцас хэрэглэл ашигладаг байсан тухай ярьсан. Малчдын дийлэнх нь үндэсний дээл хувцас МАА-н үйлдвэрлэлд тохиромжтойг цохон тэмдэглэсний зэрэгцээ сааль бэлтгэхэд эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн хувцаслах шаардлагатайг онцолж байв. Мал аж ахуйн салбар, бүтээгдэхүүн үйлдвэрлэлд эрүүл ахуйн шаардлага бүрэн хангагдахгүй байгаа нь нэг талаас малчдын ус, цахилгаан, дулаан хангамжийн дутмаг байдал, нөгөө талаас нь уг асуудалд ач холбогдол өгөх малчдын ойлголт, хандлага дутмаг байгаатай холбоотой.

Малчин эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах түвшин дэх оролцоог нэмэгдүүлэх

Малчин эмэгтэйчүүдийг чадавхжуулах, шийдвэр гаргах түвшин дэх оролцоог хангах чиглэлээр ИМПАКТ төсөл, Малчин эмэгтэйчүүдийн зөвлөгөөн, Дэлхийн зөн ОУБ, ХХАБ, Стрийм төсөл чухал үүрэг гүйцэтгэж байна. Тухайлбал ИМПАКТ төсөл төслийн шууд үр шим хүртэгчдийн жендэрийн мэдлэг ойлголтыг хөгжүүлсний зэрэгцээ эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоог нэмэгдүүлэх, орлогожуулахад чиглэсэн бодит үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Түүнчлэн хоршоодын дотор эмэгтэйчүүдийн зөвлөлийг байгуулж ажиллаж байгаа нь малчин эмэгтэйчүүдийн хувь хүний чадамжийг ахиулах, дуу хоолойгоо илэрхийлэх, олон нийтийн үйл хэрэг дэх оролцоог нэмэгдүүлэх, чадавхжуулах ажлын эхлэл болж байна. Эдгээр санаачилга нь орон нутгийн бодлого төлөвлөлт, төсөвлөлтийн гадна үлдсэн ажлууд бөгөөд ХАА, хөдөөгийн хөгжил дэх жендэрийн эрх тэгш байдлыг хангахад онцгой үүрэг гүйцэтгэж байна (Матриц 3.3).

Матриц 3.3 Залуу малчин, эмэгтэй малчдыг чадавхжуулах үйл ажиллагаа

Аймаг	Сум	Залуу малчин гэр бүлийг дэмжих чиглэлээр ямар үйл ажиллагаа хэрэгжүүлдэг вэ?	Малчин эмэгтэйчүүдийг чадавхжуулах шийдвэр гаргах түвшин дэх оролцоог хангах чиглэлээр ямар ямар төсөл, хөтөлбөр хэрэгжиж байгаа вэ?
Архангай	Жаргалант	Тухайлсан арга хэмжээ байхгүй. Малжуулах хөтөлбөр, Туслах малчин хөтөлбөр	ИМПАКТ төсөл
Архангай	Цэцэрлэг	Тухайлсан арга хэмжээ байхгүй. малжуулах хөтөлбөр, туслах малчин хөтөлөр	ИМПАКТ төсөл

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРТ БАРИМТЛАХ
ЖЕНДЭРИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Архангай	Эрдэнэбулган	Малжуулах төсөл хэрэгжүүлдэг, малчдын сургалт зохион байгуулсан.	ИМПАКТ төсөл
Хэнтий	Биндэр	Малжуулах төсөл хэрэгждэг.	Импакт төсөл Малчин эмэгтэйчүүдийн зөвлөгөөнөөс хонины ноосоор бүтээгдэхүүн үйлдвэрлэх талаар санаачилга гарсан.
Хэнтий	Биндэр		Импакт, ХХАБ-ын төсөл, Стрийм гэсэн 3 төсөл суманд хэрэгжиж байгаа.
Хэнтий	Мөрөн	Малжуулах хөтөлбөр (зээл)	ИМПАКТ төсөл
Хэнтий	АЗДТГ	Малжуулах төсөл	ИМПАКТ төсөл

Малчин эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах түвшин дэх оролцоог өнөөгийн байдлаар бид тодруулав. Судлагдсан бүх сумдад малчин эмэгтэйчүүд сумдын ИТХ-ын төлөөлөгчөөр сонгогдоогүй байна. Бүх орон нутагт ИТХ-ын дарга болон СЗД эрэгтэй, сумын ИТХ-ын төлөөлөгчдийн 77,8 хувь нь эрэгтэй, 22,2 хувь нь эмэгтэй байна. Засаг даргын зөвлөлийн гишүүдийн 70.8 хувь нь эрэгтэй, 29,2 хувь эмэгтэй байна. Тус сумдад малчдын хоршоо үүссэн бөгөөд хоршоодын дарга нарын 80 хувь нь эрэгтэй, 20 хувь нь эмэгтэй байгаагаас өөрсдийнх нь оролцооны байгууллагын хувьд ч эрэгтэйчүүд давамгайлж байна. Малчдын өөрийн санаачилгад үндэслэсэн байгууллага, нэгдлийн шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо, төлөөлөл дутмаг байна (Матриц 3.4). Малчин эмэгтэйчүүдийн улс төрийн идэвх оролцоог нэмэгдүүлэхэд хамгийн анхан шатны нэгж буюу малчдын бүлэг, нөхөрлөл, хоршоон дахь манлайллыг сайжруулахаас эхлэх нь зүйтэй.

Матриц 3. 4 Удирдлага дахь эрэгтэй, эмэгтэйчүүдийн төлөөлөл, сумдаар

Малчин эмэгтэйчүүдийн нэр	Сумын нэр	ИТХ-ын дарга	Сумын ИТХ		СЗД	ЗД-ын зөвлөл		Хоршоо-ны дарга	Хоршооны тэргүүлэгчид		Хоршооны хяналтын зөвлөл	
			Эр	Эм		Эр	Эм		Эр	Эм	Эр	Эм
Архангай	Цэцэрлэг	эр	18	3	эр	5	0	эр	4	1	3	0
Архангай	Жаргалант	эр	19	2	эр	5	2	эр	4	1	4	0
Архангай	Эрдэнэбулган	эр	21	10	эр	4	3	Хоршоо байгуулагдаагүй				
Хэнтий	Хэрлэн	эр	31	10	эм	2	5	эр	3	4	1	0
Хэнтий	Биндэр	эр	19	5	эр	4	1	эм	2	1	1	0
Хэнтий	Мөрөн	эр	11	4	эр	4	3	эр	0	3	1	0
Бүгд (хувиар)		100% эрэгтэй	119 77.8%	34 22.2%	5 эр (83.3%) 1 эм (16.7%)	24 (70.8%)	14 (29.2%)	4 эр (80.0%) 1 эм (20.0%)	13 (56.5%)	10 (43.5%)	10 (62.5%)	6 (37.5%)

Шигтгээ 3.2

ИМПАКТ төслийн дэмжлэгтэйгээр 2021 онд “Өгөөж Баян Биндэрьяа” малчдын хоршоо байгуулсан. Ер нь малчид бүгд хувьдаа машин, мотоциклтой, бие даасан байдалтай, нэгдэж нийлэх сонирхол байдаггүй. Нэгдэж хоршоо болгохын тулд нэлээн юм болсон. Мөн төслийн хөрөнгө оруулалт, дэмлэгтэйгээр агуулахтай болж байгаа. Одоо барьж дуусах дөхөж байна. Хоршооны гишүүдийн ноос, ноолуурыг хадгалж ашиглана. Хоршооны гишүүд нийлээд ноос ноолуураа угааж самнаад гадагш нь Европ руу гаргахаар бэлтгэж байгаа. Хэрэв ногдол ашиг аваад ашигтай байвал манай хоршоонд орох гээд хүмүүс харж байгаа юм шиг байна лээ.

Малчидтай хийсэн ганцаарчилсан ярилцгын тэмдэглэл, Хэнтий аймаг, Биндэр сум

Төсөл хэрэгжиж буй сумдад эмэгтэй малчдад зориулан ИМПАКТ, ФЛОМ зэрэг төслүүд өрхийн санхүүгийн боловсрол, бизнес эрхлэх болон хувь хүний чадамжийг хөгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүд хэрэгжүүлж байгаа бөгөөд үр шим хүртэгч эмэгтэйчүүдийн дунд өөрийн гэсэн орлогын эх үүсвэртэй болж, санаа бодлоо олон нийтийн өмнө илэрхийлдэг болсон зэрэг дэвшлүүд гарчээ. Архангай аймгийн Жаргалант, Цэцэрлэг сумдад ИМПАКТ төслийн үйл ажиллагаа малчин эрэгтэй, эмэгтэйчүүдийг чадавхжуулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхыг хөгжүүлэхэд чиглэжээ.

Жаргалант, Цэцэрлэг сумдын малчдын хоршоо нэгж ямаанаас олох ноолуурыг үр ашгийг нэмэгдүүлэх үүднээс Тогтвортой ноолуурын холбооны оролцоо, дэмжлэгтэйгээр экспортод эхний бүтээгдэхүүнээ гаргахаар ажиллаж байгаа нь аж ахуйгаа илүү үр ашигтай эрхлэх замаар ямаа болон малын тоо толгойг хязгаарлах шийдлийг харуулсан сайн туршлага болж болох юм.

Төсөл хэрэгжсэн сумдад эрчимжсэн МАА хөгжүүлэх чиглэлээр сул анхаарч байна. Хэнтий аймгийн Биндэр сумын тухайд энэ чиглэлд оролдлого хийсэн нь амжилттай болоогүй байна. Гэхдээ Архангайтай харьцуулахад Хэнтий аймагт туслах аж ахуй эрхлэх, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, бяслаг (уламжлалт бус) үйлдвэрлэх өөрийн гэсэн туршлага бүрдэж эхлээд байна. Гэтэл Архангай аймгийн Жаргалант, Цэцэрлэг сумдад сүү, цагаан идээний үйлдвэрлэл, үүнээс ашиг орлого нэмэгдүүлсэн баримт ховор байна. Харин ноолуур ангилан бэлтгэх, оёдол, эсгий бүтээгдэхүүн, талх, нарийн боовны үйлдвэрлэл эрхлэх зэргээр орлого нэмэгдүүлэх ажил хийгдсэн байна.

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРТ БАРИМТЛАХ
ЖЕНДЭРИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Матриц 3. 5 Малчдыг чадавхжуулах арга хэмжээ, сумдаар

Аймаг	Сум	Өрхийн төсөв санхүү, аж ахуйг зохистой хэрэглээ, зохистой төлөвлөх, хөтлөх чиглэлээр сургалт зохион байгуулдаг эсэх	Уур амьсгалын өөрчлөлтөд засан зохицох чадавхад анхаардаг эсэх	Эрчимжсэн, хагас эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэх чиглэлээр арга хэмжээ хэрэгжүүлдэг эсэх
Архангай	Жаргалант	Флом төслийн хүрээнд амьдрах ухаан, сэтгэл зүй, өөртөө итгэх итгэлийг нь нэмэгдүүлэх, хамтран ажиллах, идэвхжүүлж, нийгэмшүүлэх зорилго бүхий Гэгээн ирээдүй - 2021 төслийг 0-18 насны хүүхэдтэй өрх тэргүүлсэн 10 эмэгтэйд хамруулан хэрэгжүүлсэн. Өөрсдийгөө илэрхийлдэг болсон, бас санхүүгийн боловсрол олгосон.	Импакт төслийн сургалтууд бүгд үүнд чиглэж байгаа, ноолуураа эхний шатны боловсруулалт хийж, экспортод гаргахаар хоршоо байгуулан ажиллаж байна. Яаж арьс ширээ илүү өндөр өртөгтэйгээр борлуулах сургалтад хамрагдсан	үгүй
Архангай	Цэцэрлэг	Импакт төслийн хүрээнд хоршооны гишүүн малчдад энэ чиглэлийн сургалт зохион байгуулсан	Импакт төслийн хүрээнд 2-3 сургалтын хүрээнд авч үзсэн. Уг төслийн гол зорилго нь энэ.	үгүй
Хэнтий	Биндэр	Цагаан идээ, эсгий урлалаар бүтээгдэхүүн үйлдвэрлэж, заримыг нь борлуулж байгаа. ИМПАКТ төслөөс анхаарч буй		

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРТ БАРИМТЛАХ
ЖЕНДЭРИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Хэнтий	Биндэр	НҮБ-ын ХХАБ-ын төслийн хүрээнд 6 эмэгтэйн Эмэгтэйчүүдийн бүлгэм байгуулсан. Сүүний төслөөр тоног төхөөрөмж оруулж ирсэн. Сүүгээ боловсруулан худалдаанд гаргаж байгаа. Хүүхэд бүрт сүү хөтөлбөр хэрэгжиж байгаа, сургуульд өдөр бүр 80 литр сүү боловсруулж өгдөг. Чанарганатай, зөгийн балтай сүү, тараг, аарц, зөөхий бэлтгээд сургуульд нийлүүлдэг. Төсөл хариуцсан хүн суманд байхгүй. Стрийм төслийн хүн суманд байдаг.		Эрчимжсэн мал ахуйгаар өмнө ажиллаж байсан боловч үр дүнгүй болоод зогссон. Туслах аж ахуйн хүрээнд тахиа, зөгийн бүлгийн тоо нэмэх, цус ойртолтыг холдуулах зорилгоор сайн тооны хээлтүүлэгч авах
Хэнтий	Мөрөн	Малчин эмэгтэйчүүдийн холбооноос Малчин эмэгтэйчүүдийн чуулга уулзалт өөрсдийн мөнгөөр зохион байгуулдаг. Германы ахлах мэргэжилтнүүдийн зөвлөн туслах үйлчилгээгээр 3 төрлийн бяслаг хийж, зооринд хийж хадгалж байгаад намар хотод үзэсгэлэн худалдааны үеэр борлуулдаг. Өрхийн төсвийн сургалт зохион байгуулагдаж байгаагүй.	Уур амьсгалын чиглэлээр ХХААХҮЯ, БОАЖЯ, НҮБХААБ-ны хамтран хэрэгжүүлж буй SWEET төслийн хүрээнд зохион байгуулсан. Энэ жил газар тариалангийн ААН-тай тохиролцон малчдад газар хуваарилан, малчид малын тэжээл тарьж байгаа.	Эрчимжсэн МАА байхгүй, цахилгаан саалтуур ч байхгүй. Энэ жилээс л эрчимжсэн үхрийн ферм байгуулахаар зорьж байна. Энэ чиглэлд авч хэрэгжүүлж буй арга хэмжээ дутмаг.
<i>Эх сурвалж: ОХУШ-ний ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэл</i>				

Малчдын хүүхдийн боловсролын үйлчилгээний хамрагдалт

Малчдын хүүхдийн боловсролын үйлчилгээний хамрагдалт тэдний жендэрийн бүтэц, соёлтой холбогддог. Хүүхдээ сургахтай холбоотой малчин гэр бүл хоёр тусдаа амьдрах төлөв Архангай, Хэнтий аймгийн сумдад нийтлэг ажиглагдаж байна. Энэ нь нэг талаас дотуур байрны хүртээмж хангалтгүй, үйлчилгээний чанар эцэг эхчүүдийн хүлээлтэд нийцдэггүйгээс үүдэлтэйгээс гадна малчин эмэгтэйчүүдийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаан дахь оролцоог хязгаарлаж, өрхийн орлого буурахад нөлөөлж байна. Гэтэл зорилтот орон нутагт дотуур байрны хүртээмж болон чанарыг сайжруулахад “цэвэр ус уух боломжийг бүрдүүлэх”-ээс өөрөөр бодлого төлөвлөлтийн хувьд анхаараагүй дүр зураг ажиглагдав.

Малчдын хүүхэд асрах байгууллагын үйлчилгээний гадна үлдэж байгаагийн зэрэгцээ сургуулийн бэлтгэлтэй холбоотой асуудлыг ч дагуулж байна. Ковид-19 цар тахлын нөлөөгөөр явуулын болон нүүдлийн гэр цэцэрлэгийн үйлчилгээ 2 жил тасалджээ. Иймд малчин эмэгтэйчүүдийн МАА дахь оролцоог нэмэгдүүлэх, орлогожуулахад сургуулийн дотуур байрны үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах эсвэл багийн хувилбарт сургалт бүхий сургууль, цэцэрлэгийн үйлчилгээг нэвтрүүлэх зэргээр бодлогын шийдэл үгүйлэгдэж байна. Нөгөө талаас хүүхдээ харж сумын төвд амьдарч буй эмэгтэйчүүдийг орлогын эх үүсвэртэй болгох, санхүүгийн болон бизнесийн чадамжийг ахиулах шаардлага байна.

Матриц 3. 6 Малчдын хүүхдийн сургууль, цэцэрлэгт хамрагдалт, сумдаар

Аймаг	Сум	Малчдын хүүхдийн сургууль, цэцэрлэгт хамрагдалт
-------	-----	---

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРТ БАРИМТЛАХ
ЖЕНДЭРИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Архангай	Жаргалант	Хоолт багийн сургууль, дотуур байрны хүрэлцээ сайн биш. Цэцэрлэгт үнэндээ хамруулж чадахгүй байгаа
Архангай	Цэцэрлэг	Хоёр тусдаа амьдарч байна. Дотуур байрны үйлчилгээний чанар хангалтгүй.
Хэнтий	Биндэр	Цэцэрлэгийн асуудал гайгүй. Сургууль завсардах тохиолдол мэр сэр гарна. Малчид өрх тусдаа амьдардаг тохиолдол манай суманд олон бий. Нарийн бүртгэл байдаггүй, хүүхэд орхигдуулах асуудал гардаггүй.
<i>Эх сурвалж: Малчид, мэргэжилтнүүдтэй хийсэн ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэлээс</i>		

Ялгаварлан гадуурхалт, АББД-аас урьдчилан сэргийлэх, хамгаалах

Салбарын жендэрийн бодлогод ажлын байранд жендэрийн ялгаварлан гадуурхлаас урьдчилан сэргийлэх, санал гомдол хүлээн авч шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаанууд төлөвлөсөн. Мал аж ахуйн салбарын ажилтнуудыг аливаа ялгаварлан гадуурхал, ажлын байран дахь бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, хамгаалах харилцааг 2022 оноос мөрдөн хэрэгжүүлж буй Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулж байна.

2018-2021 оны хугацаанд урьдчилан сэргийлэхэд чиглэсэн мэдээлэл, нөлөөллийн ажлуудад хамтран ажиллах чиглэлээр хэрэгжүүлж байгаа ба мал аж ахуйн салбарын байгууллагууд байгууллагын түвшинд урьдчилан сэргийлэх, гарсан гомдлыг шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлэхэд анхаарч байна. Тухайлбал ХХААХҮЯ, түүний харьяа байгууллагууд болох Мал эмнэлгийн ерөнхий газар үүнтэй холбогдох зохицуулалтыг тусгахаар ХДЖ-аа шинэчлэн боловсруулж байна.

Хэдийгээр мэдээлэл сурталчилгаа, нөлөөллийн ажлын төлөвлөгөө гарган, дагаж мөрдүүлээгүй ч ЖҮХ зэрэг төрийн бусад байгууллага, төрийн бус байгууллага, сан, олон улсын байгууллагуудын төслийн хүрээнд мэдээлэл сурталчилгааны ажлууд явагдсан байна. Тухайлбал, “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян”, Жендэрийн үндэсний хорооноос 3-р сарын 18-ны өдрийг тохиолдуулан “Би жендэрийн хэвшмэл ойлголтын эсрэг байна” аян, Монголын эмэгтэйчүүдийн сан, Монголын орон сууц нийтийн аж ахуйн үйлчилгээний ажилтны үйлдвэрчний эвлэлийн хороотой хамтран “Дарамт, хүчирхийллээс ангид ажлын байрны төлөө” 2 өдрийн цахим сургалт зохион байгуулсан байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/22 дугаар тогтоолоор баталсан Туслах малчинтай байгуулах хөдөлмөрийн гэрээний загварт “Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд туслах малчин ялгаварлагдан гадуурхагдах, ажлын байрны дарамт, хүчирхийлэл, ажлын байрны бэлгийн дарамт, албадан хөдөлмөрт өртсөн тохиолдолд туслах малчин аймаг, дүүргийн хөдөлмөрийн хяналтын байгууллага, хүний эрхийн байгууллага болон шүүхэд хандаж шийдвэрлүүлэх эрхтэй” гэж тусгасан нь тус салбарын ажиллагсдыг хамгаалахад чиглэсэн салбар хоорондын зохицуулалтын үр дүнг илтгэж байна.

Ялгаварлан гадуурхалт, бэлгийн дарамт хүчирхийллийн талаарх малчдын ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх хэрэгцээтэйг хэд хэдэн судалгааны үр дүн харуулж

байна. Малчин эмэгтэйчүүдээс “хүчирхийлэл”-ийн талаарх ойлголттой эсэхийг тодруулахад 75.6 хувь нь мэддэг, 24.4 хувь нь мэддэггүй, мөн малчин эмэгтэйчүүдээс ямар нэгэн хүчирхийлэлд өртөж байсан эсэхийг асуухад 75.7 хувь нь өртдөггүй, 24.4 хувь нь хүчирхийлэлд өртсөн талаар дурджээ. Хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн 34.2 хувь нь бие махбодийн, 46.4 хувь нь сэтгэл санааны, 9.7 хувь нь эдийн засгийн, 9.7 хувь бэлгийн хүчирхийлэлд өртсөн талаараа илэрхийлжээ.²

² ХЭҮК. 2019. Малчин эмэгтэйчүүдийн хүний эрхийн хэрэгжилт: хүчирхийллээс ангид байх эрх, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн зарим асуудал. Улаанбаатар

Бүлэг 4. Газар тариалангийн салбарын хүний нөөцийн хөгжил, эмэгтэйчүүдийн оролцоо

Газар тариалангийн салбарт ажиллагч эмэгтэйчүүдийн ажиллах нөхцөл, ХАБЭА, нийгмийн хамгааллыг сайжруулах, зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөө аж ахуйн зохистой дадал олгох, хүнсний ногоо, жимс жимсгэний үйлдвэрлэлийн технологи, сургалт, санхүү-зээлийн үйлчилгээг жендэрийн мэдрэмжтэй хөгжүүлж, эмэгтэйчүүд ажиллах нөхцөлийг сайжруулах, тариаланч эмэгтэй, эрэгтэйчүүдийн жендэрийн ялгаатай хэрэгцээнд нийцүүлэн эзэмшүүлж, нийгмийн хариуцлагыг нь нэмэгдүүлэх, бүх түвшний хэрэглэгчдийн жендэрийн ялгаатай үүрэг ба хэрэгцээнд тулгуурлан үндэсний үйлдвэрлэлийг дэмжсэн, зохистой хэрэглээг төлөвшүүлэх үндэсний чадавхийг хөгжүүлэх зорилтуудыг дэвшүүлсэн.

Тус салбарт “Хүнсний ногоо” (2018-2022), “Жимс жимсгэнэ” (2018-2022), “Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах” (2019-2023) үндэсний хөтөлбөрүүд болон “Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян” (2020-2025) -ыг үндэсний хэмжээнд хэрэгжүүлж байна. Үндэсний хөтөлбөрүүдэд жендэрийн үзэл баримтлал нэгтгэгдээгүй, хөтөлбөрийн үр дүнг хүйсээр ангилсан мэдээллээр харуулаагүй дүр зураг ажиглагдаж байна. Тус салбарт хэрэгжүүлж буй гадаад улс орон, ОУБ-ын төслүүдийн жендэрийн бодлогын хүрээнд эмэгтэйчүүдийг дэмжих, ялгаатай хэрэгцээнд чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлж байна.

Газар тариалангийн салбарын хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах

МУЗГ-ын газар тариалангийн салбарт хүний нөөцийг хөгжүүлэх, мэдлэгт суурилсан газар тариаланг хөгжүүлэхээр зорьж байна. Салбарын жендэрийн бодлогод хүнсний ногоо, жимс жимсгэний үйлдвэрлэлийг жендэрийн мэдрэмжтэйгээр дэмжин хөгжүүлэх, органик бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ЖДҮ, өрхийн үйлдвэрлэл ажиллагч эрэгтэй, эмэгтэйчүүдийг дэмжихэд чиглэсэн мэргэжлийн зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх зорилтуудыг дэвшүүлээд байна.

Салбарын газар тариалангийн зорилтот үйл ажиллагаанд тариалан эрхлэгчдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэжилтэй ажилтан бэлтгэх, давтан сургах, мэдээллээр хангах замаар хүний нөөцийн чадавхыг тасралтгүй сайжруулах, техникийг урт хугацаатай хөнгөлөлттэй зээлээр олгох, *Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян*-д мэдлэгт суурилсан шинжлэх ухааны үндэслэлтэй үйлдвэрлэлийг хөгжүүлэх, хүний нөөцийн чадавхийг сайжруулж, хөдөлмөр эрхлэлтийн тогтвортой байдлыг хангахаар тусгажээ. ХХААХҮС-ын Салбарын жендэрийн бодлогын зорилт 2-т Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын хүний нөөцийн хөгжлийг дэмжин жендэрийн тэгш оролцоо, тэгш хариуцлагыг бүх түвшинд нэмэгдүүлэхдээ хүнсний ногоо, жимс жимсгэний үйлдвэрлэлийн технологи, сургалт, санхүү-зээлийн үйлчилгээг жендэрийн мэдрэмжтэй хөгжүүлж, эмэгтэйчүүд ажиллах нөхцөлийг сайжруулах, ялгаварлан гадуурхалт, АББД-аас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ гэжээ. Эдгээр үйл ажиллагааг 2018-2021 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 4.2

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРТ БАРИМТЛАХ
ЖЕНДЭРИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Зорилт, үйл ажиллагааны чиглэл	Үйл ажиллагаа
ХХААХҮС-ын хүний нөөцийн хөгжлийг Дэмжин жендэрийн тэгш оролцоо, тэгш хариуцлагыг бүх түвшинд нэмэгдүүлэх	<ul style="list-style-type: none"> - Органик бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, хадгалах технологийг сайжруулах, борлуулалтын сүлжээг хөгжүүлэх бүх шатанд эмэгтэй эрэгтэйчүүдийн тэгш оролцоог хангах, тэдний ялгаатай туршлага, хэрэгцээг анхаарч тооцох чиглэлээр холбогдох албан тушаалтнуудад удирдамж боловсруулан хүргүүлэх, -Ногоочдод зориулсан ногоон зээл олгох туршилтын төслийг ОУБ, ТББ-уудтай хамтран хэрэгжүүлэх, -Хүлэмжийн аж ахуй эрхлэх сургалт, хөрөнгө оруулалтын дэмжлэгийн хүртээмжийг нэмэгдүүлж, шаардагдах дэд бүтцийг хөгжүүлэх,
Ажлын байранд жендэрийн ялгаварлан гадуурхлаас сэргийлэх, гомдол барагдуулах механизмаар шийдвэрлэх, ЖСХ-д өртөгсдийг ажлын байранд нь хамгаалах, дэмжих механизмыг бүх байгууллагад бүрдүүлэх	<ul style="list-style-type: none"> - Төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх - Ялгаварлан гадуурхалт, АББД-аар санал гомдол механизмыг бий болгох, байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд тусгах - Ажилд авахад хүйс, насаар ялгаварлах, АББД-аас урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл сурталчилгаа, нөлөөллийн ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх.
Салбарын төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад ажиллагч эмэгтэй эрэгтэйчүүдийн ХАБЭА, нийгмийн хамгааллыг сайжруулж, зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих;	<ul style="list-style-type: none"> - ХХҮС-ын эмэгтэй, эрэгтэй ажиллагчдын хувьд мөрдөгдөх жендэрийн мэдрэмжтэй зохистой хөдөлмөрийн орчин нөхцөлийн жишиг шалгуур үзүүлэлтүүдийг гаргаж, төр, хувийн хэвшлийн ажил олгогчид, ажилчдад танилцуулан, ХАБ, МХЕГ-ийн Хяналт үнэлгээний тогтолцоонд нэвтрүүлэх

Газар тариалангийн салбарт ажиллагсдыг чадавхжуулах, мэргэжилтэн бэлтгэх, ХАБЭА-н талаар хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар үнэлгээнд хамрагдсан аймаг, сумдын ХАА-н асуудал хариуцсан мэргэжилтнүүд, газар тариалан эрхлэгч эмэгтэйчүүдтэй ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлага хийв. Хэнтий аймгийн ХХААГ-ын бодлогын мэргэжилтний өгсөн мэдээллээр газар тариалангийн салбарт хүнс үйлдвэрлэлийн чиглэлд хүний нөөц дутагдалтай, агрономич мэргэжлээр эмэгтэй боловсон хүчин хангалтгүй, тэтгэврийн насныхан зонхилон ажилладаг, төгсөгчдөөс газар тариалангийн салбарт ажиллагсдын хүний нөөцийн судалгаа хангалтгүй, орон нутагт газар тариалангийн салбарын хүний нөөцийг бэлтгэх, мэргэжил сонголт, ажил мэргэжлийг сурталчлах үйл ажиллагаа тааруухан байна. ХХААХҮС-т бизнес эрхлэгчдийн тоог хүйсээр гаргадаг ч, салбарын хүний нөөц, хүнтэй холбоотой асуудлыг нийгмийн хөгжлийн хэлтэс, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар хамаатуулах, газар тариалан, хүнс үйлдвэрлэлээ хариуцдаг гэх хандлага илэрч байлаа.

Шигтгээ 4.1	
<p>Жендэрийн сургалтад хамрагдаагүй. Салбар, орон нутгийн жендэрийн бодлогыг анхнаас нь салбар салбарын төлөөллийг оролцуулж өргөн хэлэлцүүлэг хийж боловсруулдаггүй. Манай салбарт агрономич, малын эмч эрэгтэйчүүд, эмэгтэй боловсон хүчин алга. Хүнсний салбарт ажиллах эмэгтэй мэргэжилтэн алга. Эдгээр асуудлыг бодлогод тусгамаар байдаг. Салбар болон орон нутгаас ийм бодлогын баримт бичиг батлагдсан талаар мэдээлэл хуваалцдаггүй. Жишээ нь АЗДТГ-т ХХААХҮ хариуцлагын бодлогын мэргэжилтнүүд ажилладаг, бидэнд салбарын жендэрийн бодлого батлагдсаныг мэдээлдэггүй.</p> <p align="right"><i>Ганцаарчилсан ярилцлага, Хэнтий аймаг, ХХААГ-ын мэргэжилтэн</i></p>	<p>Хүний нөөцийн тоон мэдээлэл хүйсээр гаргадаг ч ашиглалт муу, тайлан мэдээнд бүрэн тусгагддаггүй. Гаргая гэвэл болно.</p> <p>Малын эмнэлэг хувийн хэвшлийнх, гэтэл ихэнх нь нас ахисан хүмүүс байгаа, малын эмчийн оон тоо дутагдалтай хэвээр байгаа. Манай тасагт гэхэд мэргэжлийн мал зүйч, зоо техникч байхгүй. Салбар болон орон нутгийн зүгээс мэргэжилтнээ бэлтгэх, мэргэжил сонголтод нөлөөлөх талаар анхаарах нь сул байна.</p> <p align="right"><i>Ганцаарчилсан ярилцлага, Архангай аймаг</i></p>

Шигтгээ 4.2

Газар тариалангийн салбарт ажиллагчдыг чадавхжуулах, мэргэжилтэн бэлтгэхэд жендэрийн мэдрэмжтэй хандах тал дээр дутмаг анхаарч байгаа ч ИМПАКТ төслөөр газар тариалангийн салбарт ажиллагчдыг дэмжих чиглэлд эмэгтэйчүүдийн зөвлөл байгуулах, ӨТЭ-дэд хүнсний ногоо тариалахад зориулж газар олгох, техник хэрэгсэл, хашаа, зоориор хангах, газар тариалан эрхлэгч эмэгтэйчүүдийн зөвлөгөөн зохион байгуулах зэргээр тариаланч эмэгтэйчүүдийг чадавхжуулах чиглэлд хамтран ажиллаж буйг дурьдсан юм.

Үнэлгээнд оролцсон эмэгтэйчүүд ИМПАКТ, Каритас Чех зэрэг ОУБ-тай хамтарсан төслийн хүрээнд хэрэгжүүлсэн хүнсний ногоо эрхлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдахын зэрэгцээ бизнес эрхлэх ур чадвар, хүүхэд хамгаалал, эмэгтэйчүүдийн оролцоо, ЖСХ-ийн талаар ойлголттой болсон байна. Газар тариалангийн салбарт хүнс, ногооны үйлдвэрлэл эрхэлж буй эмэгтэйчүүдийг нэгтгэх, бүлэг хоршооны зохион байгуулалтаар ажиллахад нь ОУБ-ын төсөл хөтөлбөрүүд дэмжлэг үзүүлж байна. Хоршооны зохион байгуулалтаар ажиллах нь нэг хамт олон, бүлэг болж төлөвшдөг, хөдөлмөрөө хоршдог, эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх үр өгөөжтэй гэж судалгаанд оролцсон ногоочдын хоршоо, дундын хоршооны гишүүнчлэлтэй эмэгтэйчүүдийн төлөөлөл дүгнэжээ.

Матриц 4. 1 Газар тариалан эрхлэгч эмэгтэйчүүдийг чадавхжуулах чиглэлээр

Аймаг	Сум	Орон нутгийн эмэгтэйчүүдийг чадавхжуулах сургалтын хэрэгцээ	Эмэгтэйчүүдийг сумын нутгийн удирдлага, шийдвэр гаргах түвшин дэх оролцоог нэмэгдүүлэхэд хэрэгтэй дэмжлэг арга хэмжээ
Архангай	Эрдэнэбулган	Хоршиж ажиллах нь үр дүнтэй. Цаашид хоршоог дэмжих хэрэгтэй.	Шударга дайчин эмэгтэйчүүдийг төрд гаргах, ИНБ-аар дамжуулж оролцоог хангах
Архангай	Жаргалант	Орлого өсгөхөд анхаарах хэрэгтэй.	Олон нийт хоршооны үйл ажиллагаанд идэвхтэй оролцоог бий болгох, нээлттэй болгох
Архангай	Цэцэрлэг	Эмэгтэйчүүдэд НҮЭМ-ийн боловсрол олгоход анхаарах	Эмэгтэйчүүдийн нийгмийн оролцоог дэмжих замаар улс төрд оролцуулах
Хэнтий аймаг	Биндэр	Санхүүгийн г.м үр дүнтэй сургалтуудыг үргэлжлүүлэх	Ахмадууд, нийгмийн асуудалд анхаарах, саналаа илэрхийлдэг байх
Хэнтий аймаг	Мөрөн	Эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн сургалтууд хэрэгцээтэй	Сургалтад эмэгтэйчүүд түлхүү хамрагддаг, тэр хэмжээгээр оролцоо нэмэгдэнэ
Хэнтий аймаг	Чингис	Хоршоог хөгжүүлэх чиглэлээр сургалтууд	

Эх сурвалж: Фокус бүлгийн ярилцлага, Архангай, Хэнтий аймгийн малчин, газар тариаланч эмэгтэйчүүд

Газар тариалангийн салбарт ажиллагч эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, ур чадварыг дэмжих чиглэлээр явагдаж буй арга хэмжээний нэг нь Засгийн газраас олгож

буй 3 хувийн хүүтэй зээлийн үйлчилгээ юм. Уг зээлийг ХААН банкаар дамжуулан олгож хүлэмжийн аж ахуй, ногоо тариалах үйлдвэрлэлийг дэмжиж байна. Газар тариалангийн салбарт ажлын байрыг дэмжих зорилготой бага хүүтэй зээл гэж мэргэжилтнүүд үзсэн бол ногоо тариалагч эмэгтэйчүүдийн хувьд хугацаа богино, шалгуур өндөр, хүртээмжгүй байдаг тухай тэмдэглэсэн. Уг зээл нь тариалан эрхлэгч газрын эзний нэр дээр гардаг. Жендэрийн уламжлалт соёлын нөлөөгөөр өмч хөрөнгийн эзэмшил өрхийн тэргүүн буюу эрэгтэйчүүдийн нэр дээр бүртгэгдэг, хүнс, ногооны үйлдвэрлэл өрхийн бизнес хэдий ч эмэгтэйчүүдийн хөдөлмөр зонхилдог энэ нөхцөлд өөрийн нэр дээр зээл авах боломж, хэрэгцээг анхаарах шаардлагатай. Газар тариалангийн салбарт ажиллагч эмэгтэйчүүдийн ногоон зээлийн талаарх ойлголт сул байна.

Шигтгээ 3.2

- Зээл авах гэхээр банкны шалгуур дээр очоод гацчихдаг. Хуучин тариаланчдад өгдөг байсан зээлийг төмс, хүнсний ногоо эрхлэгчдэд тусад нь өгдөг болсон. Гэвч бид авч чадаагүй. Нөгөө талаас зээл аваад хүнсний дэлгүүр ажиллуулж байгаа юм шиг шууд эргэлтэд оруулах боломжгүй байдаг. Үүнийг тооцоолдоггүй. Жишээ нь 50 саяын зээд аваад түүгээрээ трактор авбал дараа жил нь төлөх боломжгүй, ойрын нэг, хоёр жилдээ л төлөх боломжтой.

- Зээлийн шалгуур нь өндөр байдаг. Борлуулалтын орлого шаарддаг, барьцаа хөрөнгө шаарддаг. Үүнийг хангах боломж бидэнд байдаггүй.

- Зээлийн хугацаа богино байдаг. Бага орлоготой хүн зээл авахад хэцүү. Энэ жил 3 хувийн зээлийг 4-5 хүн л авсан. Зээлийн хугацааг урт болгомоор байна.

- Өндөр хөгжилтэй орнууд ХАА-гаа хөгжүүлэхийн тулд бага хүүтэй, урт хугацаатай зээл олгож байна.

- Бид тариаланч эмэгтэйчүүдийг дэмжих талаар орон нутгийн удирдлагад залхтал нь хэлдэг. Тодорхой шийдэлд хүрэхгүй байна. Бодлогод тусгууль гэж байнга хэлдэг. Мэдэж байгаа л гэдэг. Тодорхой арга хэмжээ авч байгаа, гэсэн ч хангалттай биш байна. Зээл авах гэхээр банк биднийг аваад алга болчихно гээд айгаад байдаг юм шиг санагдсан. Нэг жилийн хугацаатай зээл авах хэцүү. Эхний 6 сард нь зээлээс чөлөөлдөг ч дараагийн 6 сард нь зээл төлөх хэцүү. Зунжин хөлсөө гоожуулж ажилласнаа буцаагаад шууд зээлд төлөх хэрэгтэй болдог. Түүний оронд урт хугацаатай, ахиухан зээл олговол авах тоног төхөөрөмжөө аваад, ургацаа гаргаж аваад бага багаар төлбөл бидэнд тустай байна. Би компаниар зээлээ авсан. Иргэний хувиар зээл авах хэцүү. Ялангуяа тэтгэвэрт гараад ногоо тарьж байгаа хүн авах боломжгүй. Сүүлийн үед л биднийг тоож байгаа болохоос өмнө биднийг хөдөлмөр хийж байна гэж анхаардаггүй байсан.

Фокус бүлгийн ярилцлага, Хэнтий аймаг, Хэрлэн сумын ногоочин эмэгтэйчүүд

Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйг сайжруулах

ХХААХҮС-ын жендэрийн бодлогыг 2018-2022 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд салбарын төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад ажиллагч эмэгтэй эрэгтэйчүүдийн ХАБЭА, нийгмийн хамгааллыг сайжруулж, зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ХШҮ-ний тогтолцоог нэвтрүүлэхээр тусгажээ. Үнэлгээнд хамрагдсан орон нутгийн түвшинд газар тариалангийн салбарт ажиллагч эмэгтэй эрэгтэйчүүдийн хэрэгцээнд нийцсэн ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл, зааварчилгаагаар хангаж буй байдлыг авч үзлээ.

Матриц 4. 2 Газар тариалангийн салбарт ХАБЭА, зохистой хөдөлмөрийн дадал олгох чиглэлд чадавхжуулах үйл ажиллагаа

Аймаг	Сум	ХАБЭА-н нөхцөлийг сайжруулах, хэм хэмжээ мөрдүүлэх, үйл ажиллагаанд зориулсан төсөв хуваарилдаг эсэх	Салбарт ажиллагч эмэгтэй, эрэгтэйчүүдийн хэрэгцээнд нийцсэн ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл, эрүүл мэндийн үзлэл үйлчилгээ, ажлын орчинд байр амьдрах сууц, хоол тэжээлийн таваг хэм хэмжээ бий эсэх
Архангай	Жаргалант	Суманд газар тариалан эрхэлдэггүй тул анхаардаггүй, төсөв хуваарилдаггүй.	Төсөв хуваарилдаггүй.
Архангай	Цэцэрлэг	Суманд газар тариалан сул хөгжсөн, төсөв хуваарилдаггүй.	ХАБЭА-н нэг бүрийн хувцас хэрэглээ, төсөв хуваарилдаггүй.
Архангай	Эрдэнэ-булган	Төсөв хуваарилдаггүй, анхаардаггүй.	Төсөв хуваарилдаггүй.
Хэнтий	Биндэр	ЗДТГ-т ХАБЭА-ийн зааварчилгаа, бичиг баримт хариуцсан мэргэжилтэн сумдуудын бүтээн байгуулалт хариуцсан мэргэжилтнүүдэд зааварчилгаа өгдөг. Мэргэжилтнүүд ХАБЭА-ийн сургалтад хамрагддаг.	Мэдээлэлгүй, ХАБЭА хариуцсан мэргэжилтэн илүү мэдээлэлтэй байрладаг.
Хэнтий	Мөрөн	Газар тариалангийн салбарт зохистой дадал олгох чиглэлд салбарын яам, ЖЭРЭС, ИМПАКТ төслөөс чадавх бэхжүүлэх сургалтуудыг зохион байгуулдаг (ямар хувцас өмсөх, хаанаас салхитай үед цацах, бороотой бол гэх мэт зөвлөгөө өгдөг). Зохистой дадлын ном, стандартыг газар тариалан эрхлэгчдэд түгээдэг.	Мэргэжлийн хүмүүсээр талбайд заавар зөвлөгөө авдаг. Хамгаалах хувцас хэрэглэл өмсөж хэвшээгүй. Нүдний нүд зүүж эхлээд байна.
Хэнтий	ЗДТГ	Хийж эхэлнэ.	Тариаланч, ногоочдын зөвлөгөөн, тариалангийн улирлаар зохистой дадал хортон хөнөөлд ажиллах асуудлаар мэргэжлийн багшаар сургалт, дадал ажил хийлгэн, тараах материал гарын авлагаар ханган, мэдээлэл түгээдэг.

Эх сурвалж: ХХААГ, тасгийн мэргэжилтнүүдтэй хийсэн ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэл

Архангай аймгийн хувьд ХАБЭА-ын асуудалд анхаардаггүй, салбарт зохистой дадал олгоход чиглэсэн арга хэмжээг төлөвлөж, төсөвлөдөггүй байна. Харин газар тариалан, хүнсний ногооны үйлдвэрлэл хөгжсөн Хэнтий аймгийн хувьд салбарын жендэрийн бодлогод тусгагдсан ХАБЭА, нийгмийн хамгааллыг сайжруулж, зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлд мэргэжлийн багш нартай хамтран сургалт, дадлага хийх, газар тариалан эрхлэгч эрэгтэй, эмэгтэйчүүдийг гарын авлага, материалаар хангах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Газар тариалангийн салбарт ажиллагчдын ХАБЭА-н нөхцөлийг сайжруулах, нэг бүрийн хамгаалах хувцас

хэрэгсэл, өдөр тутмын ХАБЭА-н зааварчилгаагаар хангах байдал дутмаг байна. Судлагдсан орон нутгийн түвшинд ХАБЭА, нийгмийн хамгааллыг сайжруулах чиглэлд төлөвлөж хэрэгжүүлж буй үйл ажиллагаа түүнд зориулсан төсөв, ХШҮ-ний тогтолцоонд хүйсээр ангилсан мэдээллийг цуглуулж, үр дүн, өөрчлөлтийг тодорхойлох чадавх сул байгааг мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлагын дүн харуулав.

Газар тариалангийн салбарт ажиллагч эмэгтэйчүүдтэй хийсэн фокус бүлгийн ярилцлагаар газар тариалан хөгжсөн эсэхээс хамаарсан ялгаа ажиглагдаж байна. Тухайлбал Архангай аймагт ихэвчлэн бага хэмжээтэй өрхийн аж ахуй эрхэлдэг онцлогтой тул ХАБЭА-г мөрдөх тал дээр цаашид анхаарах ёстой гэсэн байр суурьтай байхад Хэнтий аймагт яам, аймгийн ХХАА-н газар ХАБЭА, хөдөлмөрийн зохистой дадал олгох чиглэлд чадавхжуулах арга хэмжээг тогтмол зохион байгуулснаар химийн бодисны хэрэглээг зохистой түвшинд хэрэглэх мэдлэг ойлголт, дадалтай болжээ.

Матриц 4. 3 Газар тариалангийн салбарт ажиллагч эмэгтэйчүүдийг ХАБЭА, зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлд чадавхжуулах үйл ажиллагаа

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРТ БАРИМТЛАХ
ЖЕНДЭРИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Аймаг	Сум	Ажлаа хийхдээ аюулгүй байдалдаа санаа зовдог уу? Таны ажиллаж буй салбарт ХАБЭА-н хэм хэмжээ мөрдөгддөг үү?	Ажлын онцлог болон эмэгтэй, эрэгтэйчүүдийн хэрэгцээнд нийцсэн ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл байдаг уу? Хэрэгцээтэй эсэх
Хэнтий	Хэрлэн	Яам, ХХАГ, ОУБ-аас ХАБЭА, хөдөлмөрийн зохистой дадлын сургалт зохион тогтмол байгуулдаг. Химийн бодисын хэрэглээний талаар ойлголт нэлээд сайжирсан. Албан ёсны зөвшөөрөлтэй газраас худалдан авах, заавар зөвлөгөө заавал авах, цацах аргачлалын мэдлэг сайжирч, цацах дундын техниктэй болсон. Ногоочдын зөвлөгөөнөөр ХАБЭА-н мэдээлэл өгдөг.	Тусгай хамгаалах хэрэгсэл, хувцас шаардлагатай.
Хэнтий	Мөрөн	ХАБЭА-н сургалт, мэдээлэл өгдөг, ном, гарын авлага хангалттай ч тариаланчид унших судлах шаардлагатай. ХАБЭА-г мөрдөж ажиллах нь тааруу. Химийн бодисын заавартай өөрсдөө танилцаад дагаж мөрддөг.	Хөдөлмөр хамгааллын хувцас өмсөх ёстой (хор цацах, хүлэмжид ажиллах) гэдэг. Маск зэрэг бүрэн хамгаалалтын хувцастай байх ёстой. Хор цацахад усны гутал, малгай, маск, нүдний шил зүүнэ. ИМПАКТ төслөөс ХАА техник хэрэгсэл угсрахыг зааж хортон шавьж, ургамлын өвчнийг таних ялгах дадлага хийсэн.
Архангай	Эрдэнэбулган, Жаргалант, Цэцэрлэг	МАА түлхүү эрхэлдэг онцлогтой, өрхийн хэмжээний жижиг аж ахуй эрхлэгчид уламжлалт байдлаараа ажилладаг, цаашид анхаарах асуудал мөн.	Муу хувцсаа өмсдөг.

Эх сурвалж: Газар тариалан эрхлэгч эмэгтэйчүүдтэй хийсэн ФБЯ-ын тэмдэглэл

Шигтгээ 3.2

Хөдөлмөр хамгааллын сургалт сайн байдаг. ХААХҮЯ-наас хөдөө аж ахуйн зохистой дадал төслийн хүрээнд олон сургалт зохион байгуулдаг. Өмнө нь мэддэггүй байсан. Улсын түвшинд химийн бодисын хэрэглээний талаар ойлголт нэлээд сайжирсан. Албан ёсны зөвшөөрөлтэй газраас худалдан авах, заавар зөвлөгөө заавал авна гэх мэт. Түүнчлэн зардаг газрууд худалдан авагчдаа бүртгээд савыг нь буцаан авдаг болсон. Цацах аргачлалыг ч заадаг. Ногоочдын зөвлөгөөний үеэр мэдээлэл өгдөг. Хор цацахад дундын техниктэй болсон. Нэг эрэгтэй жолоочтой. Өөрсдөө хараад тунгаа тааруулаад өгөөд жолоочоор цацуулдаг. Ногоочдын зөвлөгөөний оролцогчдын 50-иас дээш хувь нь эмэгтэйчүүд, ихэвчлэн гэр бүлээрээ тарьдаг. Дангаараа ногоо тарьдаг эрэгтэйчүүд бий, гэхдээ цөөхөн.

Фокус бүлгийн ярилцлага, Хэнтий аймгийн Мөрөн сумын газар тариалангийн салбарт ажиллагч эмэгтэйчүүд

Газар тариалангийн салбарт ажиллагч эмэгтэйчүүдийн өгсөн мэдээллээр, гэр бүлээрээ ажилладаг, дангаараа ногоо тарьдаг эрэгтэйчүүд цөөн, хор цацах ажлыг ихэвчлэн эрэгтэйчүүд хийдэг, ногоочдын зөвлөгөөнд оролцогчдын нэлээд нь эмэгтэйчүүд байдаг гэжээ. Эндээс харахад хүнсний ногооны үйлдвэрлэлд эмэгтэйчүүдийн оролцоо давамгайлж, чадавхжуулах үйл ажиллагаанд идэвхтэй оролцоотой байна.

Тус салбарт хөдөө аж ахуйн зохистой дадлыг эзэмшүүлэх ХАБЭА сургалтууд, гарын авлагаар хангах, зааварчилгааны дагуу газар тариалан эрхлэхэд тодорхой ахиц өөрчлөлтүүд гарч байгааг үнэлгээний үр дүн харуулж байна. Түүнчлэн газар

тариалангийн салбарт ажиллагч эмэгтэйчүүдийг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах судалгааг өргөжүүлэх, үүнтэй холбоотой төсөв санхүүжилтыг шийдэх, хангах асуудал чухлаар тавигдаж байна. ХХААХҮС-ын дунд түвшний болон сумдын түвшний албан хаагчдыг бэлтгэх хэрэгцээ байгаа нь жендэрийн асуудал салбар дундын шинжтэй тул зөвхөн нийгэм, хөдөлмөр халамжийн асуудалд хамаатуулах өрөөсгөл хандлага чанарын судалгааны мэдээлэл цуглуулах явцад ажиглагдлаа.

Газар тариалангийн салбарт ажиллагч эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах түвшин дэх оролцоог хангах

Монгол Улсад жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр хийгдсэн олон судалгааны дүнгээр ЖЭТБ-ыг хангах зорилт, үйл ажиллагаанууд ОУБ, хувийн хэвшил, ИНБ-ын санхүү, техник туслалцаатайгаар хэрэгжиж ирснийг нотолдог. Бидний судалгаанд хамрагдсан Хэнтий аймгийн 2021 онд ОНЖДХ-ийн төлөвлөгөөнд эмэгтэйчүүдийн манлайлыг дэмжих оролцоонд суурилсан сургалтыг хамтран холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулахаар төлөвлөж, ИМПАКТ төслийн дэмжлэгтэйгээр хүнсний ногоо тариалдаг эмэгтэйчүүдийг бүлгийн зохион байгуулалтаар ажиллуулах, хүнсний ногооны талбайг хашаажуулж сургалтад хамруулах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлжээ. Тус аймгийн ОНЖДХ-ийг хэрэгжүүлэх 2022 оны төлөвлөгөөний 4.1-т жижиг, дунд бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн уулзалтыг зохион байгуулахаар тусгасан байна. Архангай аймгийн ОНЖДХ-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд газар тариалангийн салбарт ажиллаж буй эмэгтэйчүүдийг чадавхжуулах хүрээний үйл ажиллагааг төлөвлөгөөгүй байна.

Матриц 4. 4. Газар тариалангийн салбарт ажиллагч эмэгтэйчүүдийн ажиллах нөхцлийг сайжруулах; сургалт, санхүү-зээлийн үйлчилгээг жендэрийн мэдрэмжтэй хөгжүүлэх хүрээнд ОНЖДХ-т төлөвлөгдсөн үйл ажиллагаа түүний хэрэгжилт

2021		2022	
Архангай аймаг			
Төлөвлөгөө	Биелэлт	Төлөвлөгөө	Биелэлт
- Байхгүй	- Байхгүй	- Байхгүй	- Байхгүй
Хэнтий аймаг			
Төлөвлөгөө	Биелэлт	Төлөвлөгөө	Биелэлт

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРТ БАРИМТЛАХ
ЖЕНДЭРИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

<p>Эмэгтэйчүүдийн манлайлыг дэмжих оролцоонд суурилсан сургалтыг хамтран холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах</p>	<ul style="list-style-type: none"> - Хүнсний ногоо тариалдаг эмэгтэйчүүдийг нэгтгэн, хашаажуулж, 15 эмэгтэйг сургалтад хамруулав. - Сумдын зөвлөл ИМПАКТ төсөлтэй хамтран төсөл бичих сургалтад 20 эмэгтэйг хамруулав. - Сумдын зөвлөл малчин, ногоочин, ТАХ, бизнес эрхлэгч залуу эмэгтэйчүүдийг хүлээн авч уулзав. 	<p>- Жижиг дунд бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн уулзалтыг зохион байгуулах</p>	<p>- Дүгнэх хугацаа болоогүй</p>
--	---	--	----------------------------------

ОНЖДХ-т газар тариалангийн салбарт ажиллагч эмэгтэйчүүдийг чадавхжуулах тодорхой зорилтууд тусгагдаагүй ч эмэгтэйчүүдийн манлайллыг дэмжих хүрээнд оролцоот чадавх бэхжүүлэх, ЖДҮ, бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн уулзалтыг зохион байгуулахаар төлөвлөгөөнд тусгажээ. ОУБ-ын дэмжлэгтэйгээр хүнсний ногоо тариалдаг эмэгтэйчүүдийн хоршоог хөгжүүлэх, техник технологийн дэмжлэг үзүүлэх, ур чадварыг ахиулах сургалтуудыг зохион байгуулж байна. Түүнчлэн жил бүр газар тариалан, ногоочдын зөвлөгөөнийг зохион байгуулж байгаа нь салбарын жендэрийн бодлогыг хэрэгжүүлэх үйл хэрэгт тодорхой хэмжээгээр хувь нэмэр оруулах юм.

Бүлэг 5. Ялгаварлан гадуурхалт, АББД-аас урьдчилан сэргийлэх, хамгаалах

2018-2022 онд салбарын жөндөрийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд ялгаварлан гадуурхал, АББД-ын асуудлаар гомдлыг ил тод болон нууцаар өгөх арга зам, авах арга хэмжээ, хариуцах албан тушаалтныг хамт олны саналаар томилох талаар төр, хувийн хэвшлийн байгууллагын дотоод журамд ажлыг эхлүүлэх, ажилд авахад хүйс, насаар ялгаварлах, ажлын байран дахь бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл сурталчилгаа, нөлөөллийн ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. МАА, газар тариалангийн салбарт ихэвчлэн өрхийн аж ахуй зонхилж байгаа бөгөөд МАА, төмс, хүнсний ногоо, хүлэмжийн аж ахуй эрхлэгчдийн зохих хувийг эмэгтэйчүүд, өрх толгойлсон болон өндөр насны эмэгтэйчүүд эзэлж байна. Газар тариалан эрхлэх зарим ажлыг эрэгтэй хүн хөлслөн ажиллуулах тохиолдолд өрх толгойлсон эмэгтэйчүүдэд АББД-д өртөх эрсдэл байдаг тухай судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүд илэрхийлж байв. Эндээс өрхийн буюу бичил түвшний аж ахуй эрхлэгчдийн дунд бэлгийн дарамт, хүчирхийллийн талаарх болон асуудал тохиолдох үед ямар байгууллагад, хэрхэн хандах тухай мэдлэг ойлголт өгөх шаардлага байгаа нь ажиглагдлаа.

МАА, газар тариалангийн салбарт ажиллагч эмэгтэйчүүдэд АББД-ын талаар харилцан адилгүй мэдээлэлтэй, телевизээс мэдээлэл авдаг, энэ чиглэлээр сургалт нөлөөллийн үйл ажиллагаанд хамрагдсан туршлага хомс байна. ФБЯ-д оролцсон цөөн эмэгтэй хэрэв АББД гарвал ХЭҮК-т хандана, бусад эмэгтэйчүүдийн хувьд хэнд хандахаа мэдэхгүй байна гэж хариулжээ.

Дүгнэлт, зөвлөмж

Нэг. ХХААХҮ-ийн салбарын бодлого төлөвлөлтийг дэмжих жендэрийн эрх тэгш байдлын үзэл баримтлал, арга зүй

ХХААХҮ-ийн салбарын бодлого, төлөвлөлтийг дэмжих жендэрийн эрх тэгш байдлын үзэл баримтлал, арга зүйг нэвтрүүлэх бодлогын хэрэгжилтийн эхний үе шатны зорилт, үйл ажиллагааны хэрэгжилт хангалтгүй байна. Салбарын жендэрийн бодлогыг хэрэгжүүлэх бүтэц бүрэлдээгүй бөгөөд уг тогтолцоог хөгжүүлэхэд ХХААХҮЯ, харьяа байгууллагуудын удирдлагын манлайлал, оролцоо хангалтгүй байна. Шинээр боловсруулан баталж буй салбарын стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө, ХШҮ-нд жендэрийн дүн шинжилгээ хийгээгүй ба жендэрийн статистик мэдээлэл цуглуулах, ашиглах тогтолцоо бүрдээгүй байна. Үндэсний болон орон нутгийн бодлого төлөвлөлтөд жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн арга зүйг нэвтрүүлээгүй, салбарын жендэрийн бодлого хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаанд зохих төсөв хуваарилдаггүй байна. Орон нутгийн ХХААГ, тасгийн хүний нөөцийн дутмаг, нэг мэргэжилтэн хоёр ба түүнээс дээш орон тоонд ажиллаж байгаагаас жендэрийн асуудлыг нэмэлт ажил үүрэг болгон хүлээн авах хандлага сул байхад хүргэж байна.

Зөвлөмж:

- Салбарын яам, харьяа байгууллагууд, аймгийн ХХААГ, сумдын ХХАА-н тасгийн удирдах, гүйцэтгэх ажилтнууд, мэргэжилтнүүдийн жендэрийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээний тоо, давтамжийг нэмэгдүүлэх, холбогдох төсөв хуваарилах
- Салбарын жендэрийн бодлогыг хэрэгжүүлэхэд удирдах ажилтны манлайлал, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор албан тушаалын тодорхойлолт, ажлын үр дүнг үнэлэх шалгуурт тусгах
- Сайд, ТНДБ-ын тушаал зэрэг яамны шийдвэрийн биелэлтэд тавих хяналтыг сайжруулах, орон нутагт ажиллаж буй мэргэжилтнүүдэд арга зүйн дэмжлэг үзүүлэх
- Орон нутгийн хэрэгцээнд нийцүүлэн ХХАА мэргэжилтэн бэлтгэх, тус салбарын чиглэл тус бүрийг хариуцаж байгаа мэргэжилтнүүдийн жендэрийн талаарх мэдлэг, ойлголтыг дээшлүүлж, ажлын байрны тодорхойлолтод жендэрийн холбогдох үүргийг тусгах нь сэлгэн ажиллуулахаас илүү оновчтой хувилбар гэж үзэж байна. Салбарын жендэрийн статистик мэдээллийн сан бий болгох талаар ҮСХ-той хамтран ажиллаж, үндэсний болон салбарын хэмжээнд мэдээлэл цуглуулах загваруудыг шинэчлэн боловсруулах, үүнд хүйсээр ангилсан мэдээлэл цуглуулахаар тусгах
- Салбарт хэрэгжүүлж буй гадаад улс орнууд, олон улсын байгууллагуудын дэмжлэгтэй хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдэд жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар бий болсон сургамж, туршлагаас суралцан салбарын үндэсний болон орон нутгийн бодлогод нэвтрүүлэх

Хоёр. Орон нутгийн бодлого, хөтөлбөрийн уялдаа, бүтэц, мэдээлэл

ХХААХҮ-ийн салбарын жендэрийн бодлогыг хэрэгжүүлэх бүтэц энэхүү үнэлгээ хийсэн аймгуудад бүрэлдээгүйн зэрэгцээ салбарын ажилтнуудын мэдлэг, мэдээлэл хангалтгүй байв. Жендэрийн дэд хөтөлбөр хэрэгжиж эхэлж байгаа ч ХХААХҮ-ийн салбарын бодлоготой уялдаа сул, салбар дундын болон орон нутгийн удирдлага хоорондын зохицуулалтаас ихээхэн хамааралтай байна.

Судалгаанд хамрагдсан сумдын бодлогын баримт бичгүүдэд хөдөөгийн эрэгтэй, эмэгтэйчүүд, ХАА-н салбар дахь жендэрийн эрх тэгш байдалд хамаарах жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх, эрүүл мэнд, амьжиргааг дээшлүүлэх, эрх мэдэлжүүлэх зэрэг арга хэмжээ тусгагдсан бөгөөд хэрэгжиж эхэлсэн, хэрэгжүүлэхээр тодорхой хугацаа төлөвлөсөн, хариуцах байгууллага, албан тушаалтныг тодорхойлсон давуу тал ажиглагдав.

Бодлого төлөвлөлтөд тусгагдаагүй ч жендэрийн эрх тэгш байдлыг хангахад ач холбогдол бүхий арга хэмжээг ОУБ-аас хэрэгжүүлж буй төслийн хүрээнд хэрэгжүүлж байна. Энэ бүхэн нь орон нутгийн эрх бүхий байгууллага, удирдлагаас хэрэгжүүлэх бодлогын баримт бичигт жендэрийн үзэл баримтлалыг нэгтгэх, ОУБ-аас хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийг салбарын жендэрийн бодлоготой уяж чадвал хэрэгжилийг дэмжихэд чухал алхам болохыг харуулж байна.

Зөвлөмж:

- ХХААХҮЯ орон нутаг дахь байгууллага, нэгж, ажилтнуудад салбарын жендэрийн бодлогын талаарх мэдээллийг хүргэх, орон нутгийн бодлогын баримт бичигт зохих арга хэмжээг тусгуулахад дэмжлэг үзүүлж ажиллах.
- ХХААХҮЯ-аас ХХААХҮ-ийн салбарт хэрэгжих төсөл, хөтөлбөрт зайлшгүй анхаарвал зохих, хэрэгжүүлбэл зохих арга хэмжээнүүдийг тодорхойлж, жендэрийн үзэл баримтлалыг төсөл, хөтөлбөрт нэгтгэх ажлыг эрчимжүүлэх.

Гурав. МАА-н салбарын хүний нөөцийн хөгжил, жендэрийн эрх тэгш оролцоо

МАА-н салбарт эрэгтэй, эмэгтэй малчдад чиглэсэн бодлого хэрэгжүүлж байгаа ч тэдгээрийн бодлого төлөвлөлт, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний шатанд жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг нэгтгэж чадахгүй байна.

МАА-н үйлдвэрлэл дэх ХАБЭА-н хэм хэмжээ, стандартыг мөрдүүлэх ажил хангалтгүй байна. Сааль бэлтгэхэд эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн хувцаслах шаардлагыг хүлээн зөвшөөрсөн ч зохистой дадал хэвшээгүй байна.

Залуу малчдыг дэмжих үйл ажиллагаа малжуулах төслөөр хязгаарлаж байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд туслах малчны хөтөлбөр батлагдсан ч хэрэгжилт зорилтот орон нутгуудад эхлэл төдий байна. Түүнчлэн өрх толгойлсон эрэгтэй, эмэгтэй малчдын амьжиргааг дэмжихэд чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ байхгүй байна.

Малчин эмэгтэйчүүдийг чадавхжуулах талаар төрийн байгууллагуудаас тавих анхаарал сул, энэ ажлыг ОУБ-ын төсөл, хөтөлбөрөөр дамжуулан хэрэгжүүлж байна.

Орон нутгийн шийдвэр гаргах түвшин, малчдын бүлэг, нөхөрлөл, хоршооны удирдлага дахь эмэгтэйчүүдийн оролцоо, төлөөлөл хангалтгүй байна.

Сургуулийн дотуур байрны үйлчилгээний чанар, хүртээмж сул, хүүхэд асрах байгууллага, цэцэрлэгийн хүртээмж хангалтгүй байгаа нь малчин өрхүүдийн аж амьдралд сөргөөр нөлөөлж байна.

Зөвлөмж:

- ОНЖДХ болон ХХААХҮ-ийн салбарын жендэрийн бодлогын уялдааг хангах,
- ХНХЯ-тай хамтран ганц бие, өрх толгойлсон эрэгтэй, эмэгтэй малчдын амьжиргааг дээшлүүлэх асуудлыг холбогдох хөтөлбөрт тусгах.
- Малчин эмэгтэйчүүдийн манлайллыг хөгжүүлэх, хувь хүний чадамжийг ахиулах үүднээс малчдын бүлэг, нөхөрлөл, хоршооны удирдлага дахь эмэгтэйчүүдийн оролцоо, төлөөллийг нэмэгдүүлэхэд юуны түрүүнд анхаарах.
- Орон нутгийн удирдлага малчдын нийгмийн хамгааллыг сайжруулах, нийгмийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх чиглэлээр ХНХЯ, НДЕГ зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж, мэдээлэл хүргэхэд хамтран ажиллах
- Орон нутгийн ХХААГ малчдын ХАБЭА, хөдөө аж ахуйн зохистой дадал олгох арга хэмжээг өргөжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх
- ХХААХҮЯ-аас сургуулийн дотуур байрны чанар, хүртээмжийг сайжруулах эсвэл багийн сургууль, цэцэрлэг байгуулах, хүүхэд асрах үйлчилгээ, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд БШУЯ-тай хамтран ажиллах.

Дөрөв. Газар тариалангийн салбарын хүний нөөцийн хөгжил, жендэрийн эрх тэгш оролцоо

Газар тариалангийн салбарт хүний нөөцийн хөгжлийг хангах, эрэгтэй эмэгтэйчүүдийн эрх тэгш оролцоог хангахад чиглэсэн зорилт, үйл ажиллагааны хэрэгжилт хангалтгүй байна.

Салбарын жендэрийн бодлого нь газар тариалангийн салбарт ажиллагч эмэгтэйчүүдийн ажиллах нөхцөл, ХАБЭА, нийгмийн хамгааллыг сайжруулах, хөдөө аж ахуйн зохистой дадал олгож зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн судалгаа гаргах, мэдлэг нэмэгдүүлэх, чадавхжуулах зорилт, үйл ажиллагааг энэ үү шатанд хэрэгжүүлээгүй байна. Түүнчлэн хүнсний ногоо, жимс жимсгэний үйлдвэрлэлийн технологи, сургалт, санхүү-зээлийн үйлчилгээг жендэрийн мэдрэмжтэй хөгжүүлж, эмэгтэйчүүд ажиллах нөхцөлийг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааны хэрэгжилт үндэсний болон орон нутгийн түвшинд хангалтгүй байна. Газар тариалангийн салбарт ажиллаж буй эмэгтэйчүүд ногоон зээлийн талаар хангалттай ойлголт мэдлэггүй, салбарт олгогдож буй зээлийн бодлого нь тэдний бодит амьдралын нөхцөл байдалтай уялдахгүй байна.

Мэдлэг, хүний нөөцөд тулгуурласан газар тариаланг хөгжүүлэх бодлого баримталж байгаа энэ нөхцөлд эмэгтэй тариаланч, ногоочид чадавхжуулах арга хэмжээнд идэвхтэй оролцдог, хоршооны зохион байгуулалтаар хөдөлмөрөө хорших, улам бүр эмэгтэйчүүдийн оролцоог хүчирхэгжүүлж байна.

Зөвлөмж:

- ХХААХҮЯ-аас ЖЭТБ-ыг хангах хүрээнд салбарын ажилтнуудыг чадавхжуулах, ажлын байрны тодорхойлоход тусгах, урамшуулах, бодлогын хэрэгжилтийг хэрхэн хангаж ажиллах зааварчилгаа, удирдамж өгөх,
- Бүх түвшинд газар тариалангийн салбарт ажиллагсдын талаарх хүйсээр ангилсан тоон мэдээлэл цуглуулах, ашиглах
- Газар тариалангийн салбарт ажиллагч эмэгтэйчүүдэд ХАБЭА, зохистой дадал олгох чиглэлээр орон нутгийн чадавх бэхжүүлэх, түүнд зориулсан төсөв хуваарилах
- ХХААХҮЯ орон нутгийн тариаланч эмэгтэйчүүдийн ололт амжилтыг үргэлжлүүлэх, газар тариалан эрхлэхэд зориулсан олон төрлийн зээлийн үйлчилгээний хугацааг уртасгах, шалгуурыг багасгахад анхаарах.
- ОУБ, ИНБ, банк санхүүгийн байгууллагатай хамтран орон нутгийн удирдлагаас ногоон зээлийн ач холбогдлыг танилцуулж байгаль орчинд ээлтэй, ажлын байранд зохистой дадал олгох чиглэлээр салбарын жендэрийн бодлоготой уялдуулж хэрэгжүүлэх.
- Орон нутгийн удирдлага тариалан эрхлэгчдийн нийгмийн хамгааллыг сайжруулах, нийгмийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх чиглэлээр ХНХЯ, НДЕГ зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж, мэдээлэл хүргэхэд хамтран ажиллах

Тав. Ажлын байрны бэлгийн дарамтын асуудал

Орон нутгийн мэргэжилтнүүд, МАА, газар тариалангийн салбарт ажиллагч эмэгтэйчүүд АББД-ын талаар тодорхой ойлголт мэдээлэлтэй, нутгийн захиргааны байгууллагуудын хөдөлмөрийн дотоод журамд хориглох, гомдол хүлээн авах зохицуулалтыг хийсэн нь салбарын жендэрийн бодлогын зорилт хэрэгжиж байгааг харуулж байна. Өрхийн буюу бичил түвшинд аж ахуй эрхлэгч өрх толгойлсон эмэгтэйчүүдийн хувьд АББД-д өртөх эрсдэл байна.

Зөвлөмж:

- ЖҮХ-оос боловсруулан хүргүүлсэн удирдамж зааврыг салбарын төрийн захиргааны байгууллага, түүний харьяа байгууллагууд болон орон нутгийн захиргааны байгууллагуудын түвшинд ажил хэрэг болгон нэвтрүүлэх
- Орон нутгийн удирдлагаас өрхийн аж ахуй эрхлэгчдэд АББД болон асуудал гарсан тохиолдолд гомдол, дуудлагыг хэнд хэрхэн гаргаж болох тухай мэдээллийг хүргэх зэрэг болно.

Ашигласан материал

1. МУЗГ. 2020. Монгол улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр. Улаанбаатар
2. МУЗГ. 2018. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын талаар баримтлах бодлого, 2018-2025. Улаанбаатар
3. МУЗГ. 2018. Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр. Улаанбаатар
4. МУЗГ. 2010. Монгол мал үндэсний хөтөлбөр. Улаанбаатар
5. МУЗГ. 2020. Монгол малчин үндэсний хөтөлбөр, 2021-2024. Улаанбаатар

6. МУЗГ. 2020. Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам
7. МУЗГ. 2017. Хүнсний ногоо үндэсний хөтөлбөр, 2018-2022. Улаанбаатар
8. МУЗГ. 2017. Жимс, жимсгэнэ үндэсний хөтөлбөр, 2018-2022. Улаанбаатар
9. МУЗГ. 2019. Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах үндэсний хөтөлбөр, 2019-2023. Улаанбаатар
10. ХХААХҮЯ. 2021. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын стратеги төлөвлөгөө, 2021 -2024 он. Улаанбаатар
11. ХЭҮК. 2019. Малчин эмэгтэйчүүдийн хүний эрхийн хэрэгжилт: хүчирхийллээс ангид байх эрх, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн зарим асуудал. Улаанбаатар
12. ХЭҮК. 2021. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэл. Улаанбаатар
13. ХЭҮК. 2021. Туслах малчдын нийгэм, эдийн засгийн байдал, хүний эрхийн хэрэгжилтийн судалгааны тайлан. Улаанбаатар.
14. ҮСХ. 2019. Хөдөө аж ахуйн салбарын танилцуулга. Улаанбаатар
15. ҮСХ, НҮБЖТБЭЧБ, 2021. Жендэрийн статистик ба тогтвортой хөгжлийн үзүүлэлт, түүнийг ашиглах гарын авлага. Улаанбаатар
16. ЖҮХ, АХБ, 2021. Эрэгтэй, эмэгтэй залуу малчдын амьдрал ахуй дахь жендэрийн дүн шинжилгээ. Улаанбаатар
17. ЖҮХ, АХБ, 2020. Салбарын жендэрийн бодлогод оролцооны хяналт шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал. Улаанбаатар
18. ЖҮХ, АХБ, 2020. Орон нутгийн жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрт оролцооны хяналт шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал. Улаанбаатар
19. Архангай аймгийн ИТХ. 2020. Архангай аймгийн жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр, 2020-2024
20. Хэнтий аймгийн ИТХ. 2020. Архангай аймгийн жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр, 2020-2023
21. ХНХЯ, ОУХБ, Ололт Амжилт ХХК. 2021. Малчдад зориулсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн гарын авлага. Улаанбаатар

ТЭМДЭГЛЭЛ
